



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСЭН ХУУЛЬ



МОНГОЛ УЛСЫН ШИНЭ ҮНДЭСЭН ХУУЛЬ

New constitution of Mongolia

30
Years
ЖИЛ

Статистикийн зурагт эмхэтгэл
Illustrated statistical compendium



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

МОНГОЛ УЛСЫН
ШИНЭ ҮНДСЭН ХУУЛЬ

NEW CONSTITUTION OF MONGOLIA

30
Years
ЖИЛ

Статистикийн зурагт эмхэтгэл
Illustrated statistical compendium

Улаанбаатар
2022 он

МОНГОЛ УЛСЫН ШИНЭ ҮНДСЭН ХУУЛЬ

New constitution of Mongolia

30

Years
ЖИЛ

Эмхэтгэлийг хянасан:

Батмөнхийн БАТДАВАА ҮСХ-ны дарга
Болдсайханы ЦАЦРАЛТ ҮСХ-ны Хамтын ажиллагаа, тархаалтын хэлтсийн зөвлөх

Эрхлэн боловсруулсан:

Аюушийн ДЭМБЭРЭЛ ҮСХ-ны Эдийн засгийн статистикийн газрын дарга,
Доктор, Профессор
Дорждамбын БААСАН ҮСХ-ны Хамтын ажиллагаа, тархаалтын хэлтсийн ахлах
статистикч
Шалзадын СЭРЖХҮҮ Ахмад ажилтан, Эдийн засагч-статистикч
Бидэръяагийн ЦЭРЭНХАНД Ахмад ажилтан, Инженер-программист

Эхийг бэлтгэсэн:

Цогтбаатарын МӨНХЦЭНГЭЛ ҮСХ-ны Хамтын ажиллагаа, тархаалтын хэлтсийн
дизайнер

Хаяг:

Засгийн газрын III байр
14200, Улаанбаатар, Монгол Улс

Мэдээллийн үйлчилгээ:

Утас: 1900-1212, 70141212
Факс: (976-11)-321433
Цахим шуудан: information@nso.mn
Цахим хуудас: www.nso.mn

©Эмхэтгэлийг зөвшөөрөлгүйгээр олшруулах дахин хэвлэхийг хориглоно.

Edited by:

BATDAVAA Batmunkh Chairman, NSO
TSATSRALT Boldsaikhan Advisor, Cooperation and dissemination division, NSO

Developed by:

DEMBEREL Ayush Director, Economic statistics department, NSO, Ph.D, Professor
BAASAN Dorjdamba Senior statistician, Cooperation and Dissemination division, NSO
SERJKHUU Shalzar Retired officer, Economist-statistician
TSERENKHAND Bideriya Retired officer, Engineer-programmer

Publication design by:

MUNKHTSENDEL Tsogtbaatar Designer, Cooperation and dissemination division, NSO

Address:

Government building III
14200, Ulaanbaatar, Mongolia

Information service:

Tel: 1900-1212, 70141212
Fax: (976-11)-321433
E-mail: information@nso.mn
Web site: www.nso.mn

© All rights reserved



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ЗӨВЛӨЛ

THE BOARD OF DIRECTORS,
NATIONAL STATISTICS OFFICE OF
MONGOLIA

ӨМНӨХ ҮГ

Монгол Улс ардчилсан шинэ Үндсэн хуулиа баталсны түүхт 30 жилийн ой 2022 онд тохиож байна. Манай улс түүхэндээ 1924, 1940, 1960, 1992 онд Үндсэн хуулиа шинэчлэн баталсан.

1992 онд улс төрийн тогтолцоог шинэчлэн, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн ардчилсан Үндсэн хууль баталж, зах зээлийн эдийн засагт шилжсэн. Шинэ Үндсэн хууль нь Монголд ардчилсан нийгэм хөгжих суурийг зангидан бэхжүүлсэн төрийн гол хууль болж чадсан билээ.

Шинэ Үндсэн хууль бол Монгол Улсын тусгаар тогтнолыг бататгасан, иргэдийг нийгмийн бүлэг, үзэл бодлоор ялгаварлалгүй, нийтлэг ашиг сонирхлыг нь хамгаалсан, хууль сахин хамгаалах хяналт тогтоосон гэж иргэд нийтээр хүлээн зөвшөөрдөг.

Үндэсний Статистикийн Хорооноос толилуулж буй шинэ Үндсэн хуулийн ойд зориулсан энэхүү статистикийн зурагт эмхэтгэл нь манай улсын нийгэм, эдийн засагт 30 жилийн хугацаанд гарсан өөрчлөлт, шинэчлэлийг харуулсан түүхэн баримт болно.

Энэхүү эмхэтгэлд багтсан мэдээллийг бодлого, хөтөлбөр боловсруулах, шинжилгээ судалгаанд өргөнөөр ашиглах боломжтой гэдэгт итгэлтэй байна.

FOREWORD

In 2022, Mongolia marks the 30th anniversary of the adoption of a new democratic Constitution. The country adopted its Constitution four times, namely in 1924, 1940, 1960 and 1992.

Reforming its political system and ratifying the democratic Constitution that strengthens human rights and freedoms, Mongolia launched its transition to a market economy in 1992. The new Constitution has become a fundamental law of the nation that strengthens the foundation for development of democratic society in Mongolia.

It is widely acknowledged by the citizens that the new Constitution strengthens the independence of Mongolia, protects the common interest of its citizens without discriminating against them on the basis of social class and opinion, and establishes rule of law.

This statistical compilation dedicated to the 30th anniversary of the new Constitution, presented by the National Statistical Office, is a historical document that shows the changes and reforms that have taken place in the society and economy of our country over the past 30 years.

We hope that the data contained in this compilation will be used in policy and program development and research.



“Үндсэн хууль бол тогтворжсон
нийгмийг бататгасан бус, харин
төлөвших нийгмийн үндсийг
бэхжүүлсэн хууль юм”

*“Constitution does not consolidate
the established society but strengthens
the foundation of developing society”.*

Монгол Улсын ардчилсан шинэ Үндсэн хуулийн эхийг
баригч, Гавьяат хуульч БЯРААГИЙН ЧИМИД

*MR CHIMID BYARAA
Principal author of the new democratic Constitution of Mongolia and
Honoured Lawyer*

МОНГОЛ УЛСЫН ШИНЭ ҮНДСЭН ХУУЛЬ

New constitution of Mongolia



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЗАМНАЛ

The historical timeline of the Constitution of Mongolia

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ БҮТСЭН ТҮҮХЭН ЗАМНАЛ

Монгол Улс 1924, 1940, 1960, 1992 онуудад Үндсэн хуулиа дөрвөн удаа хэлэлцэн баталсан түүхтэй.

Монгол Улсын анхдугаар Үндсэн хууль

1924 оны 11-р сарын 26-ны өдөр БНМАУ-ын Анхдугаар Үндсэн хууль батлагдсан. Үндсэн хуулиа баталснаар Хаант засаглалыг халж, Монгол Улсыг “Бүрэн Эрхт Бүгд Найрамдах Улс мөн” хэмээн тусгаар тогтнолоо Үндсэн хуулиар тунхагласан нь түүхэнд тэмдэглэгдэх үйл явдал болсон юм.

Анхны Үндсэн хуулийг боловсруулахдаа АНУ, Их Британи, Бельги, Норвег, ЗХУ, Швед, Япон зэрэг улсуудын Үндсэн хуулийг орчуулж, судалж байжээ.

Улсын Анхдугаар Үндсэн хууль нь “Монголын жинхэнэ ардын эрх чөлөөг илтгэн тунхаглах нь, Улсын дээд эрхийг барих газрын тухай, Нутгийн захиргааны тухай, Сонгох, сонгогдох эрхийн тухай, Улсын орлого, зарлагын эрхийн тухай, Улсын тамга ба сүлд тэмдэг, туг далбаа гурвын тухай” гэсэн 6 бүлэг, 50 зүйлээс бүрдэж байв.

Монгол Улсын хоёрдугаар Үндсэн хууль

Монгол Улсын хоёр дахь Үндсэн хуулийг 1940 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Улсын 8 дугаар Их Хурлаар баталсан байна.

Тус Үндсэн хууль нь 12 бүлэг, 95 зүйлтэй бөгөөд хүний эрх, эрх чөлөөний асуудлыг түлхүү тусгаснаараа ач холбогдолтой гэж үздэг. Тухайлбал, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын албан хаагчдын өдрийн ажлын хэмжээг найман цагаар хязгаарлах, иргэд үнэ төлбөргүй сурах, тэтгэвэр тэтгэмж авах, эмэгтэйчүүд аж ахуй, улсын ба соёл, боловсрол, улс төр, олон нийтийн бүхий л төрлийн ажил хэрэгт эрэгтэй хүний нэгэн адил тэгш эрх эдлэх, нутаг дэвсгэрийн дотор өөрийн биеэр чөлөөтэй шилжин явах ба оршин суух газраа шилж, сонгох эрхтэй хэмээн тусгасан юм.



**МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН
СҮЛД 1924-1940 ОН**

***THE STATE EMBLEM OF
MONGOLIA, IN 1924-1940***

THE HISTORICAL TIMELINE OF THE CONSTITUTION OF MONGOLIA

Mongolia has replaced and adopted its Constitution four times in 1924, 1940, 1960 and 1992.

The first Constitution of Mongolia

On 26 November, 1924, the first Constitution of the Mongolian People's Republic was adopted. The adoption of the Constitution overthrew the monarchy and declared the independence of the country, proclaiming Mongolia as a sovereign republic.

To develop the first Constitution, the constitutions of the United States, Great Britain, Belgium, Norway, Soviet Union, Sweden, and Japan were translated and studied.

The first Constitution had 50 articles and 6 chapters, which includes declaration of true freedom of the Mongolian people, institutions holding the supreme power of the state, local administration, the right to vote and to be elected, state authority over income and expenditure, and the state seal, emblem and flag.

The second Constitution of Mongolia

The Second Constitution of Mongolia was approved by the 8th State Great Khural on 30 June, 1940.

This Constitution, containing 12 chapters and 95 articles, is considered important as it placed more emphasis on human right and freedom aspects. Specifically, it specified the eight hour per day work restriction for workers in the Mongolian People's Republic, the universal access to education and pensions, and the equal exercise by women of the right to participate in all economic, state, cultural, educational, political, and public activities, and the citizens' right to move freely within the territory and to choose the place of their residence.



**МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН
СҮЛД 1940-1960 ОН**

**THE STATE EMBLEM OF
MONGOLIA, IN 1940-1960**

Монгол Улсын гуравдугаар Үндсэн хууль

Монгол Улсын 3 дахь Үндсэн хуулийг 1960 оны 7 дугаар сарын 6-ны өдөр баталжээ. Энэхүү Үндсэн хууль 10 бүлэг, 94 зүйлтэй бөгөөд тус хуульд 13 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Энэ үеэс улс орныг хөдөө аж ахуйн орноос аж үйлдвэрийн орон болгох үйл явц эрчимжсэн, хот байгуулалтын хөгжлийн онцлог үе эхэлсэн түүхтэй.

Монгол Улсын дөрөвдүгээр Үндсэн хууль

Монгол Улс ардчилсан нийгэмд шилжсэний дараа 430 депутат бүхий Ардын их хурал 76 хоногийн турш хэлэлцэж, Монгол Улсын дөрөвдүгээр Үндсэн хуулийг 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр баталжээ.

Энэхүү Үндсэн хууль нь оршил, 6 бүлэг, 70 зүйлтэй бөгөөд 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан юм.

Монгол Улсын шинэ Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт

Улсад тусгаар тогтнол, иргэнд эрх чөлөө, эрх тэгш байдал, төрд ардчилсан дэглэм тогтоосон шинэ Үндсэн хууль нь тухайн үеийн олон улсын жишигт нийцсэн, нийгмийн шилжилтийн үед тохируулсан баримт бичиг учир хожим нэмж засварлах зайлшгүй шаардлагатайг Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Гавьяат хуульч Б.Чимид онцолсон байдаг.

Хамгийн сүүлд буюу 2019 оны 6 дугаар сарын 6-ны өдөр УИХ-ын 62 гишүүн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн. Уг төслийг 2019 оны 11 дүгээр сарын 14-нд эцэслэн баталсан юм.

Ингэхдээ Үндсэн хуулийн 28.5 хувь буюу 70 зүйлийн 19 зүйл, 36 заалтыг хөндсөн. Эдгээр өөрчлөлтөөр засаглалын хяналт, тэнцлийг хангаж, Засгийн газрын тогтвортой байдал, парламентын хариуцлагыг нэмэгдүүлж, нутгийн захиргааны бие даасан байдлыг бэхжүүлэхэд чиглэж, 2000 оны 7 өөрчлөлтийн зургааг нь засаж сайжруулжээ.



**МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН
СҮЛД 1960-1992 ОН**

***THE STATE EMBLEM OF
MONGOLIA, IN 1960-1992***



**МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН СҮЛД
1992-ОНООС ӨНӨӨГ ХҮРТЭЛ**

**THE STATE EMBLEM OF
MONGOLIA, SINCE 1992**

The third Constitution of Mongolia

The third Constitution of Mongolia was adopted on 6 July, 1960. This Constitution had 10 chapters and 94 articles, and underwent 13 amendments.

This period was marked by periods of acceleration of the development of industries and urban development.

The fourth Constitution of Mongolia

After the Mongolia's transition to democracy, the People's Great Khural, composed of 430 members, discussed the fourth Constitution for 76 days and ratified it on 13 January, 1992.

This Constitution has a preamble, 6 chapters and 70 articles. It was amended on 14 December, 2000.

Recent amendment to the new Constitution of Mongolia

Honored lawyer of Mongolia B. Chimid once emphasized that the new Constitution, which strengthens the independence of the country, guarantees individual freedom and equality, and establishes a democratic regime in the state, is a document that meets international standards at that time and is adapted to the period of social transition, it needs to be amended later. Most recently, on 6 June, 2019, 62 members of Parliament submitted a draft amendment to the Constitution of Mongolia. The amendment was finally approved on 14 November, 2019.

In doing so, the amendment covers 28.5 percent or 19 articles and 36 articles related to 70 articles of the Constitution. The amendment is aimed at strengthening the governance and rule of law, enhancing the stability of the government and parliamentary accountability, strengthening local government autonomy, and revising six of the seven amendments to the Constitution, made in 2000.



1989

Монгол Улс **1918 оны** анхны хүн амын тооллогоор **647.5 мянган** хүн амтай байжээ. **1935-1989 онд** нийт **8** удаагийн тооллого зохион байгуулсан юм. **1989 онд** нийт хүн амын тоо **2.04 сая** болсон байна.

Нийт хүн ам **1962 онд 1 сая, 1988 онд 2 сая, 2015 онд 3 сая** хүрч байсан бол Хүн ам, орон сууцны тооллогын **2020 оны** мэдээлэлд үндэслэсэн хэтийн тооцооллоор Монгол Улсын харьяат хүн ам **2033 онд 4 сая, 2048 онд 5 саяд** хүрэхээр байна.

*According to the first Population Census in **1918**, Mongolia had a population of **647.5** thousand. During the period **1935-1989**, a total of **8** censuses were conducted. In **1989**, the number of the population reached **2.04 million**.*

*The total population reached **1 million** in **1962**, **2 million** in **1988**, and **3 million** in **2015**. According to the Population Projection based on data from the **2020** Population and Housing Census, Mongolia's population is expected to reach **4 million** in **2033** and **5 million** in **2048**.*

Нийслэлийн “Хүрээ” амаржих газар. 1989 он
“Khuree” maternity hospital in the Capital city, 1989



Улсын их дэлгүүр, 1989 он
State Department Store, 1989

1980-аад оны сүүлчээр Социалист хамтын нөхөрлөл задарч, тусламж дэмжлэг зогссон тул эдийн засаг уналтын үед шилжив. Манай улсын эдийн засгийн өсөлт **1981 онд 8.4 хувьтай** байсан бол **1990 онд 2.5 хувиар** буурч байжээ.

*In the late **1980s**, the country started witnessing an economic recession following the collapse of the Soviet Union and the CMEA and the cessation of their aid. While the economic growth equalled **8.4 percent** in **1981**, the economy contracted by **2.5 percent** in **1990**.*



Жагсаал, Сүхбаатарын талбай, 1989 он
Demonstration, Sukhbaatar Square, 1989

Монголд Ардчилсан хувьсгалын анхны цуглаан **1989.12.10**-ны өдөр Улаанбаатар хотын “Хүүхэд залуучуудын соёлын төв”-ийн гадаа талбайд болов. Улс төрд олон намын тогтолцоотой болох, хүний эрхийг дээдлэх, бүх нийтийн сонгуулийг хугацаанаас нь өмнө буюу **1990 оны** эхний хагаст багтаан явуулах, улс төрийн хэлмэгдэгчдийг цагаатгах, хэвлэлийн эрх чөлөөг баталгаатай болгох зэрэг **13 зүйл** бүхий шаардлага тавьжээ.

*The first demonstration of the Democratic Revolution in Mongolia was held on **10 December, 1989**, in the square outside the Children and Youth Cultural Center in Ulaanbaatar. Following the gathering, demonstrators presented **13 demands**, including an establishment of multi-party system, respect for human rights, an early general election in the first half of **1990** before the due date, acquittal of political victims, and a guarantee of the freedom of press.*

1990

Сүхбаатарын талбайд **1990.03.07-09**-ний өдрүүдэд үргэлжилсэн улс төрийн өлсгөлөнд МоАХ-ны Ерөнхий зөвлөлийн **15 гишүүн** оролцов.

***Fifteen members** of the General Council of the Mongolian Democratic Union (MDU) took part in a political hunger strike in Sukhbaatar Square on **7-9 March, 1990**.*



Ардчилсан холбооны анхны зохицуулагч Санжийн Зориг, 1990 он
Zorig Sanj, the first leader of the Democratic Union, 1990





ХАНГАМЖ
ХЭЭР
ХАХУУЛЬ!

АЭМӨ

ХҮНИЙ ЭХЭДЭЛЭЙН
ЗЭРГЭЭЛЭЙН
ХАМГААГАХ

Жагсаал, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн соёлын төв ордон, 1990 он
Demonstration, Palace of the Central Council of Mongolian Trade Union, 1990



Жагсаал, Сүхбаатарын талбай, 1990 он
Demonstration, Sukhbaatar square, 1990

Тэмцлийн үр дүнд Монгол Улсын иргэн өмчтэй байх эрхийг Ардчилсан шинэ үндсэн хуулиар тунхаглав.

Үндсэн хуулийн **3** дугаар бүлэгт “Төр нь нийтийн ба хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэж заасан нь иргэд өөрийн өмчийг захиран зарцуулах эрхийг баталгаажуулсан юм.

As a result of the revolution, the new democratic Constitution declares that the Mongolian citizens have the right to possess property.

The third chapter of the Constitution states that the state recognizes all forms of both public and private property and shall protect the rights of the owner by law. This confirms the right of the citizens to manage their own property.



Улсын бага хурлын гишүүд, 1990 он
Members of the State Baga Khural, 1990

1990.07.29-ний өдөр Монгол Улсад анх удаа олон намын оролцоотой ардчилсан, чөлөөт сонгууль болж, **430** депутаттай Ардын Их Хурлын анхдугаар чуулган нээлтээ хийжээ. Энэхүү сонгуулиар МАХН **343**, МоАН **23**, МҮАН **7**, МСДН **4**, Монголын чөлөөт хөдөлмөрийн нам **1** суудал авч, **51** бие даан нэр дэвшигч сонгогдож байв.

*On 29 July, 1990, multi-party democratic and free election was held in Mongolia, and the first session of the People's Great Khural with **430** members opened. As a result of this election, the MPRP won **343** seats while the Mongolian Democratic Party gained **23** seats, the Mongolian National Democratic Party **7** seats, the Mongolian Social Democratic Party **4** seats, the Mongolian Free Labor Party **1** seat, and independent candidates **51** seats.*



БНМАУ-ын Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат, 1990 он
Ochirbat Punsalmaa, The President of the Mongolian People's Republic, 1990



Ардын Их Хурлын дарга Жамбын Гомбожав, 1990 он
Gombojav Jamba, Chairman of the People's Great Khural of the Mongolian People's Republic, 1990

1990.09.03-ны өдөр БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатуудын **12 дахь** удаагийн сонгуулийн Анхдугаар чуулганаар Жамбын Гомбожав Ардын Их Хурлын даргаар, БНМАУ-ын Ерөнхийлөгчөөр Пунсалмаагийн Очирбат нар сонгогдов.

On 3 September, 1990, at the first session of the 12th election of the People's Great Khural of the Mongolian People's Republic, Gombojav Jambyn was elected as Chairman of the People's Great Khural and Ochirbat Punsalmaa was elected as President of the Mongolian People's Republic.



Монгол Улсын Ерөнхий сайд Дашийн Бямбасүрэн, Төрийн ордон, 1990 он
Byambasuren Dash, Prime Minister of Mongolia, Government palace, 1990

Монгол Улсын Ерөнхий сайдаар Дашийн Бямбасүрэн томилогдож, **1990-1992 онд** ажиллаж байв.

Byambasuren Dash was appointed as the Prime Minister of Mongolia, served between 1990 to 1992.

1991

1991.01.18-ны өдөр Монголын хөрөнгийн биржийг байгуулж, **1992.02.07**-нд Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа явуулж, Засгийн газрын өмч хувьчлалын бодлогын хүрээнд Улсын өмчит үйлдвэрийн **475** газрыг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлжээ.

Ингэснээр **8.2 тэрбум** төгрөгийн үнэлгээ бүхий **96.1 сая** ширхэг хувьцааг иргэдэд хөрөнгө оруулалтын эрхийн бичиг болгон тараасны дүнд нийт хүн амын **52 хувь** нь хувьцаа эзэмшигч болов.

*The Mongolian Stock Exchange was established on **January 18, 1991**, and the primary market trading started on **7 February, 1992**. Under the privatization policy of the Government, **475** state-owned factories were transformed into joint-stock companies.*

*As a result, **96.1 million** shares worth MNT **8.2 billion** were distributed to the citizens of Mongolia as investment certificates, and **52%** of the total population became shareholders.*



Монголын хөрөнгийн бирж, 1991 он
Mongolian stock exchange, 1991



Налайхын нүүрсний уурхай. 1991 он
The Nalaikh coal mine, 1991

Монгол Улсын хэмжээнд **1991 онд 7.0 сая** тонн нүүрс олборлож байсан бол **2020 онд 43.8 сая** тонныг олборлосон нь тус хугацаанд **6.2 дахин** өссөн үзүүлэлт юм. Манай улс **2019 онд** хамгийн их буюу **55.8 сая** тонн нүүрс олборложээ.

*Mongolia mined **7.2 million tons of coal in 1990** and **43.8 million tons in 2020**, **6.2 times** increase over 30 years. In **2019**, Mongolia produced the largest amount of coal, **55.8 million tons of coal**.*



Нэгдүгээр бага сургууль, Баянхонгор аймаг. 1990 он
First secondary school, Bayankhongor aimag, 1990

1991 онд “БНМАУ-д албан хэргийг Монгол бичгээр хөтлөн явуулах болон түүний бэлтгэл ажлыг хангах тухай” Улсын Бага Хурлын **36** дугаар тогтоол гарчээ. Улмаар төрийн албан хэргийг Монгол бичгээр бичих, мөн сурагч, оюутнууд, нийт иргэдэд Монгол бичиг заах багш бэлтгэж эхлэв.

*In 1991, the State Baga Hural Resolution **No. 36** concerning preparation of official documents in Mongolian script in the Mongolian People’s Republic and preparations for necessary measures was issued. Subsequently, teachers were trained to write official documents in Mongolian script and to teach Mongolian script to students and the public.*

Монгол Улсын анхны Ерөнхийлөгчийн санаачилгаар “Алт хөтөлбөр”-ийг **1991.11.01**-ний өдөр Засгийн газар батлан хэрэгжүүлж эхэлжээ. Хөтөлбөр хэрэгжсэнээр **1992-2001 онд 16.1 тонн** алт экспортолсон бол **2002-2012 онд 138.5 тонн** болж өсжээ. Алтны экспорт **2020 онд 30.5 тонн** хүрч, нийт экспортын орлогын **23.6 хувийг** бүрдүүлж байна. Монгол Улсын хэмжээнд **1991 онд 0.7 тонн** алт олборлож байсан бол **2020 онд 20.2 тонн** алт олборложээ.

2005 онд 24.1 тонн алт олборлосон нь өнгөрсөн **30 жилийн** хувьд хамгийн өндөр үзүүлэлт байсан юм.

*At the initiative of the first President of Mongolia, the Gold Program was approved by the Government on **1 November, 1991**. As a result of the program, **16.1 tons** of gold was exported between **1992** and **2001** and the export increased to **138.5 tons** between **2002** and **2012**. Gold export reached **30.5 tons** in **2020**, accounting for **23.6 percent** of total export earnings. Mongolia mined **0.7 tons** of gold in **1991** and **20.2 tons** of gold in **2020**.*

*In **2005**, it mined **24.1 tons** of gold, the highest level over the past **30 years**.*



Эмэгтэйчүүд алт угааж буй байдал. Төв аймгийн Заамар сум, 1991 он
Women washing gold. Zaamar soum, Tuv aimag, 1991

1992

Монгол Улсын Ерөнхий сайдаар Пунцагийн Жасрай томилогдож, **1992-1996** онд ажиллаж байв.

*Jasrai Puntsag was appointed as the Prime Minister of Mongolia, served between **1992 to 1996.***



Монгол Улсын Ерөнхий сайд Пунцагийн Жасрай, 1992 он
Jasrai Puntsag, Prime Minister of Mongolia, 1992




Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбатад Шинэ Үндсэн хууль гардуулж буй нь, 1992 он
Presenting the new constitution to President Ochirbat Punsalmaa, 1992

БНМАУ-ын Ардын Их Хурлаар **1992.01.13**-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуулийг батлав. “Үндсэн хуулийг **1992.02.12**-ны **12.00** цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө” гэж заажээ. Шинэ үндсэн хууль нь **6 бүлэг, 70 зүйлээс** бүрдэх бөгөөд **1999, 2000, 2019** онуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

*The Constitution of Mongolia was adopted by the People’s Great Khural of the Mongolian People’s Republic on **January 13, 1992**. The Constitution came into effect nationwide on **February 12, 1992**, at noon. The new constitution consists of **6 chapters and 70 articles**, was amended in **1999, 2000, and 2019**.*

Монгол Улс 1992 онд **0.8 тонн** алт олборлож байсан бол **2020** онд **20.2 тонн** болж, **1992** онтой харьцуулахад **25.3 дахин** өссөн байна.

*Mongolia mined **0.8 tonnes** of gold in **1992** and **20.2 tonnes** of gold in **2020** and up **25.3 times** compared to **1992**.*



Алтны уурхай. 1992 он
Gold mine, 1992



Сүхбаатарын талбай, 1990 он
Sukhbaatar Square, 1990

Хөдөлмөрийн нөөцийн балансаар хувиараа хөдөлмөр эрхлэгчид **1992** онд **76.3 мянга** байсан бол **2020** оны байдлаар ажиллах хүчний судалгааны үр дүнгээр **205.4 мянга** болж, **2.7 дахин** өсжээ.

According to the Labour Force Balance, the number of self-employers was **76.3 thousand** in 1992 while it reached **205.4 thousand** in 2020, up **2.7 times**.



УИХ-ын гишүүд хууль баталж буй нь, 1992 он
Members of State Great Khural voting the bill, 1992

1992.04.04-ний өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг УИХ-аас батлан гаргав. Манай улс **1992** оноос хойш Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын, Орон нутгийн бүх сонгуулийг мажоритар системээр явуулсан бөгөөд зөвхөн **2012** оны УИХ болон орон нутгийн сонгуулийг пропорциональ системээр явуулжээ.

*On **4 April, 1992**, the Law on Parliamentary Elections of Mongolia was approved by the Parliament. Since **1992**, our country has held all presidential, parliamentary, and local elections in the majoritarian system, except that the **2012** parliamentary and local elections were held through the proportional system.*



Хүнсний 50 дугаар дэлгүүр, 1992 он
50th supermarket, 1992

БНМАУ-ын Засгийн газрын “Эдийн засгийг зах зээлийн зохицуулалтад шилжүүлэх” зарим арга хэмжээний тухай **20 дугаар** тогтоолыг **1991.01.15**-ны өдөр гаргасан байна. Ингэснээр үнийг чөлөөлж, бүх төрлийн барааны үнэ өсөж, инфляцын түвшин **1992 онд** түүхэндээ хамгийн өндөр буюу **325.5 хувьд** хүрчээ.

*The Government of the People's Republic of Mongolia passed Resolution **No. 20** on some measures towards transition to market economy on **15 January, 1991**. As a result, prices were liberalized, thereby prices of all types of commodities increased and bringing inflation to a record high or **325.5 percent** in 1992.*



УИХ-ын гишүүд, 1992 он
Members of the State Great Khural, 1992



УИХ-ын дарга Нацагийн Багабанди, 1992 он
Bagabandi Natsag, Chairman of the State Great Khural, 1992

Шинэ Үндсэн хуулийн хүрээнд анхны УИХ-ын сонгууль **1992.07.20**-ны өдөр болж, **1085.2 мянган** сонгогчийн **1037.4 мянган** хүн буюу **95.6 хувь** нь саналаа өгсөн байна. Сонгуулийн үр дүнгээр МАХН **70**, МоАН-МҮДН-НН-ын эвсэл **4**, МСДН **1**, Бие даан нэр дэвшигч **1** суудал авч, УИХ-ын даргаар Нацагийн Багабандийг сонгожээ.

*In the light of the new Constitution, the first parliamentary election was held on **20 July, 1992**, and **1037.4 thousand** people or **95.6 percent** of the **1085.2 thousand** voters casted their votes. As a result of the election, the MPRP won **70** seats, the coalition of the Mongolian Democratic Party, the Mongolian National Progress Party, and the Green Party **4** seats, the Mongolian Social Democratic Party **1** seat, and an independent candidate won **1** seat, and Bagabandi Natsag was elected as Chairman of the Parliament.*

1993

1993.06.18-ны өдөр Шинэ Үндсэн хуулийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхны сонгуулийг зохион байгуулж, **1026.0 мянган** сонгогч саналаа өгчээ. Нэр дэвшигч Пунсалмаагийн Очирбат нийт сонгогчдын **57.8 хувийн** саналаар анхны Ерөнхийлөгчөөр сонгогдов.

*On 18 June, 1993, the first presidential election of Mongolia was held under the new Constitution and **1026.0 thousand** voters casted their votes. Ochirbat Punsalmaa was elected as the first President of Mongolia with a **57.8 percent** majority.*

Монгол Улсын анхны Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат, 1993 он
Ochirbat Punsalmaa, The first President of Mongolia, 1993





Сонин борлуулах цэг, Улаанбаатар хот, 1993 он
A kiosk, Ulaanbaatar city, 1993

1990-ээд оноос чөлөөт хэвлэлийн үндэс суурь тавигдав. **1991 оны 7** дугаар сард **155** сонин шинээр гарч байсан бол **1993 он** гэхэд **270** хүрч өсжээ.

Иргэдэд радио, телевизийн сувгаар мэдээлэл хүргэх ажлыг МҮОНРТ гүйцэтгэж байсан бол **1992 онд** Монголын хамгийн анхны хувийн телевиз, **1995 онд** анхны хувийн **FM** радио тус тус байгуулагдсан байна.

Since **1990s**, the foundation of free press was laid. By **July 1991**, there were **155** newspapers newly published and by **1993**, the number of newspapers increased to **270**.

Before 1992, the Mongolian National Broadcaster did play a role in communicating information and news through radio and television channels and Mongolia's first private television station was established in **1992**, and the first private FM radio station was established in **1995**.



Гандантэгчинлэн хийд, 1993 он
Gandan monastery, 1993

1990 оноос эхлэн сүм, хийдийг эргэн сэргээж, хийдэд лам хуврагууд суух болжээ. **1993 онд** улсын хэмжээнд **93** сүм, хийдэд **1790** лам, шашны сургууль, дацанд **520** гаруй шавь сурагч сурч байв. **2020** оны байдлаар манай улсад нийт **410** сүм, хийд үйл ажиллагаа явуулж байгаагаас **36.6 хувь** нь Буддын, **54.1 хувь** нь Христийн, **6.6 хувь** нь Исламын, **2.7 хувь** нь бусад шашны сүм хийд байна. **2020** онд улсын хэмжээнд **1740** лам, санваартан, номлогч, **178** сурагч байна.

*At the outset of **1990**, monasteries were rebuilt and monks settled in them. In **1993**, there were **1790** monks in **93** monasteries nationwide, and more than **520** lama students in religious schools. As of **2020**, there are **410** monasteries in Mongolia, of which **36.6 percent** are Buddhist, **54.1 percent** are Christian, **6.6 percent** are Islamic and **2.7 percent** are other religions. In **2020**, there are **1740** monks, priests, imams and **178** students in religious schools.*


1994

Монголчуудын шашин, соёлын Их шүтээн Мэгжид Жанрайсиг бурхныг Гандантэгчинлэн хийдэд бүтээв. **20 тонн** зэсийн цутгамал, **27 тонн** ган бүхий энэхүү бурхныг Монголчуудын өргөл, хандиваар бүтээн байгуулсан юм. Бурхныг **75600 ширхэг** алтан ялтсаар бүрхэж, очир алмаз, маргад эрдэнэ, бадмаараг, индранил, молор эрдэнэ зэрэг **2000 гаруй** төрлийн үнэт эрдэнийн чулуугаар чимсэн байна. Эдгээр үнэт эрдэнийн **300** нь зөвхөн титмийн чимэглэлд оржээ. Бурхны их биеийг тариа дээжис, төрөл бүрийн идээ, ундаа, **27 тонн** эмийн ургамал, арц, Буддын сургаалын **332 эмхэтгэл** ба тайлбар ариун судар, Буддын ховор хувцас хэрэглэл болон **2 сая** тарни бүхий ном мөн бүрэн тавилгатай гэр, морин хуур, **9** эрдэнийн чулуугаар дүүргэсэн байна. Бурхны гартаа барьсан хадгийг Энэтхэгийн **7** өнгийн хоргой, **500 метр** цэвэр торгоор урлажээ.

28 метр өндөр ба Монголын хамгийн том буюу **1.65 метр** өндөр тахилын ширээ сэнтийлсэн Мэгжид Жанрайсиг бурхныг **1996.10.27**-ны өдөр залжээ.

*Megjid Janraisig, a great religious and cultural idol of Mongolians, was re-created at Gandan Tegchinlen Monastery. The statue, made of **20 tons** of copper and **27 tons** of steel, was re-created with donations from the people of Mongolia. The statue is covered with **75600** gold plates and adorned with more than **2000** types of precious stones, including diamonds, emeralds, rubies, sapphires, and topazes. **300** of these gems are used for decorating the statue crown. The body of the statue is filled with grain samples, various foods and beverages, **27 tons** of herbs and juniper, **332** compilations and commentaries of Buddhist scriptures, rare Buddhist costumes, and books containing **2 million** mantra, as well as a fully furnished ger, a horse fiddle, and 9 gemstones. The hand-held khadag is made of **7** color Indian brocade and **500 meters** of pure silk.*

*On **27 October, 1996**, Megjid Janraisig, standing **28 meter** tall and on a **1.65 meter** high pedestal, the largest in Mongolia, was enthroned.*



Мэгжид Жанрайсиг бурхны бүтээн байгуулалт, 1994 он
Building of Megjid Janraisig statue, 1994



Улсын Их Хурлын гишүүд, 1994 он
Members of the State Great Khural, 1994

Улсын Их Хурал **1994.12.30**-ны өдөр Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийг батлав. Нийт төрийн албан хаагчдын тоо 1995 онд **141.5 мянга** байсан бол 2020 онд **205 мянгад** хүрчээ. Үүний **66 хувийг** төрийн үйлчилгээний, **22.2 хувийг** төрийн тусгай, **10 хувийг** төрийн захиргааны, **1.8 хувийг** төрийн улс төрийн албан хаагч эзэлж байна.

On **30 December, 1994**, the State Great Khural of Mongolia approved the Law on Civil Service. The total number of civil servants increased from **141.5 thousand** in 1995 to **205 thousand** in 2020. Of these, **66 percent** are support service officers, **22.2 percent** are special service officers, **10 percent** are public administration officers, and **1.8 percent** are political officers.



Үнэт цаасны тухай хууль батлав, 1994 он
The Securities law was adopted by the State Great Khural, 1994

1994 онд УИХ-аас Үнэт цаасны тухай анхны хуулийг батлан гаргаж, Үнэт Цаасны Хороог байгуулжээ. Монголын Хөрөнгийн Биржийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж байсан брокерын **29 пүүсийг** хувьчилсан байна.

*In 1994, the State Great Khural adopted the Law on the Securities and established a Securities Committee. **29 brokerage** firms, financed by the Mongolian Stock Exchange, were privatized.*

Монгол Улс **1994 онд 2** сувгаар буюу МҮОНРТ, Улаанбаатар телевизээр нийтлэл, нэвтрүүлэг, мэдээллийн хөтөлбөр хүлээн авдаг байсан бол **2020 оны** байдлаар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо **80**, арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо **65**, төлбөртэй телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо **11**, радиогийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо **64**-т тус тус хүрсэн байна.

In 1994, Mongolia used to have two television channels, namely MNB and UBTV. As of 2020, there were 80 broadcasters, 65 commercial TV service providers, 11 paid TV service providers, and 64 radio broadcasting service providers.



Халтар царайт кино үзэж байгаа иргэд, 1994 он
People watching first soap opera broadcasted in Mongolia, 1994

1995

1995 онд Чингис хааны хөрөг бүхий нүүртэй, эртний Хархорин хотын дотоод талбайн дүрсийг агуулсан **72x150 мм** хэмжээтэй арван мянгатын мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргажээ. Таван мянгатын мөнгөн тэмдэгтийг **1994 онд** гаргаж байсан бол 20 мянгатын мөнгөн тэмдэгтийг **2006 онд** гүйлгээнд гаргасан байна.

In 1995, a 72x150 mm ten thousand togrog banknote with a portrait of Chinggis Khaan and interior of the ancient city Kharkhorin was released. A five thousand togrog banknote was released in 1994 while a twenty thousand togrog banknote were released in 2006.



Арван мянгатын мөнгөн дэвсгэрт гүйлгээнд гаргав, 1995 он
Banknote of MNT 10,000 was issued, 1995



Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийн хайлуулах цех, 1995 он
Smelter of the Darkhan Metallurgical Plant, 1995

1990 оны 7 дугаар сард хар төмөрлөгийн үйлдвэрийн шавыг тавьж, 1994 онд ашиглалтад бүрэн оруулав. Хар төмөрлөгийн импорт 1995 онд **16.1 мянган** тонн байсан бол 1996-2001 онд импортын жилийн дундаж хэмжээ **15.7 мянган** тонн болжээ.

*The country laid the foundation stone of a metallurgical plant in July, 1990, and the plant started its operation in 1994. Imports of ferrous metals were **16.1 thousand** tons in 1995, but the average annual import volume decreased to **15.7 thousand** tons in 1996-2001.*

1996

Улсын Их Хурлын **2 дахь** удаагийн сонгууль **1996.07.18**-ны өдөр болж, **1147.3 мянган** сонгогчийн **1057.2 мянга** буюу **92.1 хувь** нь санал хураалтад оролцжээ. Сонгуулийн дүнгээр МҮАН-МСДН-ын Ардчилсан холбоо эвсэл **50**, МАХН **25**, МУНН **1** суудал авч, Раднаасүмбэрэлийн Гончигдорж УИХ-ын даргаар сонгогдов.

The second parliamentary election was held on **July 18, 1996**, and **1057.2 thousand** or **92.1 percent** of **1147.3 thousand** citizens participated in the voting. As a result of the election, the Democratic Union of MNDP and the MSDP gained **50** seats, the MPRP **25** seats, and the Mongolian United Conservative Party **1** seat. Gonchigdorj Radnaasumberel was elected as Chairman of the Parliament.



УИХ-ын дарга Раднаасүмбэрэлийн Гончигдорж, 1996 он
Gonchigdorj Radnaasumberel, Chairman of the State Great Khural, 1996



Улсын Их Хурлын гишүүд, 1996 он
Members of the State Great Khural, 1996



Монгол Улсын Ерөнхий сайд Мэндсайханы Энхсайхан, 1996 он
Enkhsaikhan Mendsaikhan, Prime Minister of Mongolia, 1996

1996 оны УИХ-ын сонгуулиар “Ардчилсан холбоо” эвсэл ялалт байгуулж, Монгол Улсын Ерөнхий сайдаар Мэндсайханы Энхсайхан томилогдож, **1996-1998** онд ажиллав.

*The Democratic Union Coalition won the parliamentary election of **1996**, and Enkhsaikhan Mendsaikhan was appointed as the Prime Minister of Mongolia, served between **1996 to 1998**.*



Гар утас хэрэглэгч эмэгтэйчүүд, 1996 он
Women with mobile phone, 1996

Гар утас хэрэглэгчдийн тоо 1996 онд **889** байсан бол 2020 онд **4.4 саяд** хүрчээ. 1996 онд үүрэн холбооны **1 оператор** үйл ажиллагаа явуулж байсан бол 2020 онд **4 оператор** үйл ажиллагаа явуулж байна.

*The number of mobile subscription increased from **889** in 1996 to **4.4 million** in 2020. The number of mobile operators increased from **1** in 1996 to **4** in 2020.*



Төв номын сангийн автобусны буудал, Улаанбаатар хот, 1996 он
Bus Station in front of Central Library, Ulaanbaatar, 1996

1994 онд манай улсын ажиллагчдын тоо **759.8 мянга** байсан бол 2020 онд **1162.9 мянга** болж, **53.1 хувиар** нэмэгдсэн байна.

The number of employees in the country was **759.8 thousand in 1994** and it reached **1162.9 thousand in 2020**, up **53.1 percent**.



Mercury market, Ulaanbaatar city, 1996

1989 онд худалдааны салбарын нийт үйлдвэрлэл **2.5 тэрбум** төгрөг байсан бол 1996 онд **121.2 тэрбум** төгрөг болж, **48.5 дахин** өсжээ. 2020 онд тус үзүүлэлт **5.7 их наяд** төгрөг хүрч, үнийн нөлөөллийг арилган тооцвол, 1996 онтой харьцуулахад **6.2 дахин** нэмэгдсэн байна.

In 1989, the total trade output was **MNT 2.5 billion**, whereas in 1996, it reached **MNT 121.2 billion**, up **48.5 times**. Adjusted by inflation, it reached **MNT 5.7 trillion**, **6.2 times** higher than the level in 1996.



Дэнжийн мянга зах, Улаанбаатар хот, 1996 он
Denjiin myanga market center, Ulaanbaatar city, 1996

Жижиглэн худалдааны салбарын нийт үйлдвэрлэл **1996 онд 100.1 тэрбум** төгрөг байсан бол **2020 онд 3.1 их наяд** төгрөг болж, **30.6 дахин** нэмэгдсэн байна. Харин үнийн нөлөөллийг арилган тооцсоноор **2020 онд 405.3 тэрбум** төгрөг болж, 1996 оноос **4.1 дахин** нэмэгджээ.

Gross output of retail trade amounted to **MNT 100.1 billion** in 1996 and reached **MNT 3.1 trillion** in 2020, up **30.6 times**. According to inflation adjusted estimation, it reached **MNT 405.3 billion** in 2020, up **4.1 times** from 1996.



1997

1997.06.18-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн **2 дахь** удаагийн сонгууль болж, **1155.2 мянган** сонгогчийн **982.6 мянга** буюу **85.1 хувь** нь саналаа өгчээ. Нэр дэвшигч Нацагийн Багабанди нийт сонгогчийн **60.8 хувийн** саналаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдов.

*On June 18th, 1997, the second presidential election of Mongolia was held and **982.6 thousand** or **85.1 percent** of **1155.2 thousand** voters casted their votes. Bagabandi Natsag was elected as the President of Mongolia with a **60.8 percent** of voters.*

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслол, 1997 он
Mongolian Presidential Inauguration Ceremony, 1997

1998

Мэндсайханы Энхсайханы тэргүүлсэн Засгийн газар огцорч, Монгол Улсын Ерөнхий сайдаар **1998** оны **4 дүгээр** сард Цахиагийн Элбэгдоржийг томилло. Тэрээр **8** сарын хугацаанд ажилласан юм.

The government led by Enkhsaikhan Mendsaikhan stepped down and Elbegdorj Tsakhia was appointed as the Prime Minister of Mongolia on April of 1998. He served for 8 months.



Монгол Улсын Ерөнхий сайд Цахиагийн Элбэгдорж, 1998 он
Elbegdorj Tsakhia, Prime Minister of Mongolia, 1998



Иргэд төр нийгмийн нэрт зүтгэлтэн С.Зоригийн гэгээн дурсгалыг хүндэтгэв, 1998 он
Citizens paying tribute to the memory of S.Zorig, 1998

Ардчилсан хөдөлгөөний анхны зохицуулагч, төр нийгмийн нэрт зүтгэлтэн Санжаасүрэнгийн Зориг **1998.10.02**-ны өдөр бусдын гарт амь насаа алдав. Тэрээр УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, Дэд бүтцийн хөгжлийн сайдын үүрэг гүйцэтгэгчээр томилогдон ажиллаж байсан юм.

*Zorig Sanjaasuren, the first coordinator of the Democratic Movement and a prominent politician, was murdered on **2 October, 1998**. He was a Member of the Parliament, Member of the Government, and Acting Minister for Infrastructure Development.*



Монгол Улсын Ерөнхий сайд Жанлавын Наранцацралт гадаадын зочид төлөөлөгчидтэй уулзалт хийж буй нь, 1998 он
Narantsatsralt Janlav, Prime Minister of Mongolia meets with representatives of foreign guests, 1998

1998 оны 12 дугаар сард Жанлавын Наранцацралт Монгол Улсын Ерөнхий сайдаар томилогдож, **7** сарын хугацаанд ажилласан юм.

On **December of 1998**, *Narantsatsralt Janlav* was appointed as the Prime Minister of Mongolia, served for **7** months.



Мэргэжилтний 20 дугаар дэлгүүрийн автобусны буудал, 1998 он
Bus station of Mergeljiltnii 20th supermarket, 1998

Цахилгааны эрчим хүчний үйлдвэрлэл **1991** онд **3228.6** сая кВт.цаг, **1998** онд **2675** сая кВт.цаг байжээ. Харин **2020** онд **7069.7** сая кВт.цаг болж, **1998** оноос **2.2** дахин нэмэгдсэн байна.

Electricity production was **3228.6** million kWh in **1991** and **2675** kWh in **1998**. In **2020**, it reached **7069.7** million kWh, which is **2.2 times** more than in **1998**.

Монгол Улс **1998** оноос газрын тос экспортолж эхэлсэн. Газрын тосны экспорт **1998** онд **44.8** мянган баррель байсан бол **2020** онд **4.1** сая баррельд хүрч, 1998 оноос **91.6** дахин өсжээ.

*Mongolia has been exporting crude oil since **1998**. Crude oil exports increased from **42.8 thousand** barrels in 1998 to **4.1 million** barrels in **2020**, an increase of **91.6 times**.*



Цагаан элсний нефтийн орд, Дорнод аймаг, 1998 он
Tsagaan els oil deposit, Dornod aimag, 1998



Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат Цагаан элсний нефтийн хайгуулын явцтай танилцаж байгаа нь, 1998 он
President Ochirbat Punsalmaa visits an oil exploration site of the Tsagaan els, 1998

Монгол Улс 1998 онд **44.8 мянган** баррель газрын тос олборлосон бол 2020 онд **4.1 сая** баррель газрын тос олборложээ.

Олборлолт 2015 онд **8.7 сая** баррель хүрсэн нь түүхэн дэх хамгийн өндөр үзүүлэлт юм.

*in 1998, producing **44.8 thousand** barrels in 1998 and **4.1 million** barrels in 2020.*

*In 2015, **8.7 million** barrels of crude oil were extracted, the highest level on record.*


1999

Зудын улмаас улсын хэмжээнд **800.1 мянган** мал хорогдсон нь нийт малын **2.4 хувийг** эзэлж байжээ.

1999 онд манай улсын нийт малын тоо **33.6 саяд** хүрсэн бөгөөд адуу **3.2 сая**, үхэр **3.8 сая**, тэмээ **355.6 мянга**, хонь **15.2 сая**, ямаа **11 сая** болжээ.

*Due to the dzud, there was a loss of **800.1 thousand** livestock at the national level, accounting for **2.4 percent** of the total livestock.*

*In 1999, the total number of livestock in our country amounted to **33.6 million**, of which **3.2 million** were horses, **3.8 million** were cattle, **355.6 thousand** were camels, **15.2 million** were sheep, and **11 million** were goats.*



Зудын улмаас хорогдсон мал, Малчин сум, Увс аймаг, 1999 он
Loss of livestock due to the dzud, Malchin soum, Uvs aimag, 1999



Монгол Улсын Ерөнхий сайд Ренчиннямын Амаржаргал, 1999 он
Amarjargal Renchinnyam, Prime Minister of Mongolia, 1999

1996-2000 онд Засгийн газар **3** удаа огцорсон. Монгол Улсын Ерөнхий сайдаар **1999** оны **7** дугаар сард Ренчиннямын Амаржаргал томилогдож, **2000** оны **7** дугаар сарын **26**-ны өдөр хүртэл ажиллаж байв.

*Between **1996-2000** three governments resigned. **On July of 1999**, Amarjargal Renchinnyam was appointed as the Prime Minister of Mongolia working until on **26 July 2000**.*



2000

Хүн ам, орон сууцны **9 дэх** удаагийн тооллого **2000 онд** явагдаж, **2373.5 мянган хүн** тоологдов. Улсын хэмжээнд зохион байгуулагдсан тус тооллого нь НҮБ-ын удирдамж, зөвлөмжүүдийг голчлон удирдлага болгосон, олон улсын стандартад нийцсэн, анхны орчин үеийн тооллого байлаа.

*The **9th** Population and Housing Census was conducted in **2000** and **2373.5 thousand** persons were counted. This national census was the first modern census to be guided by the UN principles and recommendations and in line with international standards.*

Цаатан гэр бүл, Хөвсгөл аймаг
A Tsaatan family, Khuvsgul aimag



УИХ-ын гишүүд, 2000 он
Members of the State Great Khural, 2000



Монгол Улсын Ерөнхий сайд Намбарын Энхбаяр, 2000 он
Enkhbayar Nambar, Prime minister of Mongolia, 2000



УИХ-ын дарга Лхамсүрэнгийн Энэбиш, 2000 он
Enebish Lkhamsuren, Chairman of the State Great Khural

Монгол Улсын Их Хурлын **3 дахь** удаагийн сонгууль **2000.07.02**-ны өдөр болж, **1247 мянган** сонгогчийн **1028 мянга** буюу **82.4 хувь** нь саналаа өгчээ. Сонгуулийн дүнгээр МАХН-**72**, ИЗ-НН-ын эвсэл **1**, МҮАН-МШАН-ын Ардчилсан холбоо эвсэл **1**, Эх орон-МАШСН **1**, бие даагч **1** суудал тус тус авч, УИХ-ын даргаар Лхамсүрэнгийн Энэбишийг сонгов.

The third parliamentary election of Mongolia was held on **2 July 2000**, and **1028 thousand** or **82.4 percent** of **1247 thousand** citizens voted. As a result of the election, the MPRP won **72** seats, the CWP-MGP **1** seat, the Democratic Union Coalition **1** seat, Motherland-MDNSP **1** seat, and independent candidates **1** seat, and Enebish Lkhamsuren was elected as Chairman of the Parliament.



Зудын нөхцөл байдал, Эрдэнэцогт сум, Баянхонгор аймаг, 2000 он
Dzud situation, Erdenetsogt soum, Bayankhongor aimag, 2000

Монгол Улс зудын аюулд нэрвэгдэж, **3.5 сая** мал хорогджээ. Жил дараалсан зудын аюул нь ард иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлөв. Эдийн засгийн өсөлт 2000 онд **1.1 хувь** болж, өмнөх оноос **2 нэгж** хувиар саарав. Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг **16.3 хувиар** буурчээ.

*Mongolia experienced the dzud, which resulted in a loss of **3.5 million** livestock. Back-to-back dzuds adversely affected people's livelihoods. In 2000, the economic growth was **1.1 percent**, down **2 percentage points** from the previous year. Value added of the agricultural sector decreased by **16.3 percent**.*



Мянганы замын бүтээн байгуулалт, Дашинчилэн сум, Булган аймаг, 2000 он
Millenium road's work progress, Dashinchilen soum, Bulgan aimag, 2000

Мянганы зам төслийг санаачлав. Мянганы зам төсөл нь баруунаас Баян-Өлгий аймагас Дорнод аймаг хүртэл **2625 км**, Босоо тэнхлэгийн хувьд Алтанбулагийн чөлөөт бүсээс Замын-Үүд, Улаан байшинт-Баян-Өлгий-Ховд-Ярант гэсэн чиглэлийг хамарсан замын төсөл юм.

*A Millennium Road Project was launched. It was designed to construct a **2625 km** road network, connecting Bayan-Ulgii aimag in the west with Dornod aimag in the east, and linking the Altanbulag free zone in the north with Zamyun-Uud in the south and Ulaan Baishint-Bayan-Ulgii-Khovd-Yarant in the vertical direction.*



Үйлчилгээний төвүүд орон сууцны 1 давхарт баригдаж эхлэв, 2000 он
Service centers started springing up on the ground floor of apartments, 2000

Нийтийн хоолны салбарын нийт үйлдвэрлэл **2000** онд **16.5 тэрбум** төгрөг байсан бол **2020 оны** байдлаар **712.9 тэрбум** төгрөг болж, 2000 оноос **43.2** дахин нэмэгдсэн байна. Харин үнийн нөлөөллийг арилган тооцсоноор 2020 онд **179.3 тэрбум** төгрөг болж, 2000 оноос **10.9 дахин** нэмэгджээ.

Gross output of food service activities amounted to **MNT 16.5 billion** in **2000** and reached **MNT 712.9 billion** in **2020**, up **43.2 times** from 2000. According to price adjusted estimation, it reached **MNT 179.3 billion** in **2020**, up **10.9 times** from 2000.

2001

Монгол Улсын Ерөнхийлөгчийн **3 дахь** удаагийн сонгууль болж, **1 сая** сонгогч санал хураалтад оролцжээ. Нийт сонгогчдын **581.4 мянга** буюу **58.1 хувийн** саналаар Нацагийн Багабанди Монгол Улсын Ерөнхийлөгчөөр улиран сонгогдов. Нэр дэвшигч Р.Гончигдорж **365.4 мянга**, нэр дэвшигч Л.Дашням **35.4 мянган** сонгогчийн санал тус тус авчээ.

The third presidential election was held and 1 million citizens voted. Bagabandi Natsag was re-elected as President of Mongolia by 581.4 thousand or 58.1 percent of the total votes. Candidate R. Gonchigdorj gained 365.4 thousand votes while candidate L. Dashnyam had 35.4 thousand votes.



Монгол Улсын Ерөнхийлөгч Нацагийн Багабанди, 2001 он
Bagabandi Natsag, President of the Mongolia, 2001



УИХ-ын дарга Санжбэгзийн Төмөр-Очир, 2001 он
Tumur-Ochir Sanjibegz, Chairman of the State Great Khural, 2001



Баянхонгор аймгийн Бөмбөгөр суманд гар аргаар алт олборлож буй иргэд, 2001 он
Artisanal gold miners in Bumbugur soum, Bayankhongor aimag, 2001

Манай улс **2001** онд **13.7** тонн алт олборлож байсан бол **2020** онд **20.2** тонн болж нэмэгдсэн байна. Мөн экспортод **2001** онд **0.1** тонн алт гаргаж байсан бол **2020** онд **30.5** тонн болж өсжээ.

Our country mined **13.7 tons** of gold in **2001** and the volume of mined gold increased to **20.2 tons** in **2020**. Also, it exported **0.1 tons** of gold in **2001** and **30.5 tons** of gold in **2020**.

МОНГОЛ УЛС ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛАХ ЗЭВСЭГТ ХҮЧИНТЭЙ БАЙНА

ХҮЙ



2002



Энхийг сахиулагчид, 2002 он
Peacekeepers, 2002

Монгол Улс НҮБ-ын Энхийг сахиулах үйл ажиллагаанд гишүүнээр элсэж, Өмнөд Африк тивийн Сахарын нутагт анх удаа **2 ажиглагч** илгээв. Монгол Улс нь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд илгээсэн цэргийн алба хаагчийнхаа тоогоор тэргүүлдэг **24 орны** нэг юм. 2002 онд анхны хоёр цэргийн ажиглагч офицерыг Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс руу илгээснээс хойш өнөөг хүртэл давхардсан тоогоор нийт **18144**, үүнээс **732** эмэгтэй цэргийн алба хаагч энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн байна. Монгол Улсын энхийг сахиулагчид Бүгд Найрамдах Өмнөд Судан, Исламын Бүгд Найрамдах Афганистан Улс, Бүгд Найрамдах Судан Улсын Абей муж, Йемен, Баруун Сахар, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс зэрэг дэлхийн мөргөлдөөний халуун бүсэд НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байна.

*Mongolia became a member of the United Nations Peacekeeping Mission and sent two observers to Sahara and South Africa for the first time. Mongolia is one of the top **24 countries** in the world in terms of the number of troops sent to UN peacekeeping operations. A total of **18144** military personnel with double counting, including **732** women, have served in peacekeeping operations since 2002 when the country sent the first two military observer officers to the Democratic Republic of the Congo. Mongolian peacekeepers are involved in UN peacekeeping operations in the hotspots of global conflicts, including the Republic of South Sudan, the Islamic Republic of Afghanistan, Abei Province of the Republic of Sudan, Yemen, Western Sahara, and the Democratic Republic of the Congo.*

2003

Монгол Улсаас ОХУ-д төлөх “Их өр” **11.7 тэрбум** шилжих рубль байсан бөгөөд үүний **98 хувийг** ОХУ тэглэж, үлдсэн **2 хувь** болох **250 сая** ам.долларыг төлөх шийдвэр гаргав.

*Russia decided to write off **98 percent** of Mongolia's debt of **11.7 billion** in convertible rubles and remaining **2 percent, USD 250 million**, was repaid by Mongolia.*





Улсын Их дэлгүүрийн өмнөх зогсоол, 2003 он
Parking in front of the State Department Store, 2003

Авто тээврийн салбарын орлого **2003** онд **32.7** тэрбум төгрөг байсан бол **2020** онд **564.4** тэрбум төгрөг болж, **17.3 дахин** нэмэгджээ. Харин үнийн нөлөөллийг арилган тооцсоноор **2020** онд **130.4** тэрбум төгрөг болж, **2003** оноос **4.0 дахин** нэмэгдсэн байна.

Road transport revenue was **MNT 32.7 billion** in **2003**, and reached **MNT 564.4 billion**, up **17.3 times** in **2020**. According to price adjusted estimation, it reached **MNT 130.4 billion** in **2020**, up **4.0 times** from **2003**.

2004

Улсын Их Хурлын **4 дэх** удаагийн сонгууль болж, **1329.8 мянган** сонгогчийн **1088.3 мянга** буюу **81.8 хувь** нь саналаа өгчээ. Сонгуулийн дүнгээр МАХН **37**, Эх орон-Ардчилал эвсэл **35**, Бүгд Найрамдах нам **1**, бие даан нэр дэвшигч **3** суудал тус тус авч, УИХ-ын даргаар Намбарын Энхбаярыг сонгов.

The **4th** election for the State Great Khural was held and **1088.3 thousand** or **81.8 percent** of **1329.8 thousand** electors voted. As a result of the election, **37** from the MPRP, **35** from Motherland-Democracy Coalition, **1** from the Republican Party, and **3** from independent candidates were elected to the Parliament, and Enkhbayar Nambar was elected as Chairman of the Parliament.



УИХ-ын дарга Намбарын Энхбаяр, 2004 он
Enkhbayar Nambar, Chairman of the State Great Khural, 2004



УИХ-ын гишүүд, 2004 он
Members of the State Great Khural, 2004



Монгол Улсын Ерөнхий сайд Цахиагийн Элбэгдорж, 2004 он.
Elbegdorj Tsakhia, Prime minister of Mongolia, 2004

2004 оны УИХ-ын сонгуульд Эх орон-Ардчилал эвсэл хамгийн олон суудал авч, Монгол Улсын Ерөнхий сайдаар Цахиагийн Элбэгдорж томилогдож, **2004-2006** онд ажилласан юм.

*At the **2004** parliamentary election, the Motherland and Democracy Coalition won a majority and Elbegdorj Tsakhia was appointed as Prime Minister. He served between **2004 to 2006**.*



Эрдэнэт үйлдвэр, Орхон аймаг, 2004 он
Erdenet Mining Corporation, Orkhon aimag, 2004

Манай улсын эдийн засгийн өсөлт 1969 онд **14.5 хувь**, 1973 онд **11.0 хувиар** өсөж байсан бол 1980 оноос хойш анх удаа 2004 онд хоёр оронтой тоонд буюу **10.6 хувьд** хүрчээ. Энэ өсөлтөд уул уурхай, олборлолтын салбар **30.5 хувь**, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа **19.3 хувь**, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур **16.2 хувиар** өссөн нь голлох нөлөө үзүүлжээ.

Mongolia's economic growth was **14.5 percent** in 1969 and **11.0 percent** in 1973. It reached double digits or **10.6 percent** in 2004 for the first time since 1980. The growth was mainly due to a **30.5 percent** increase in mining and quarrying, a **19.3 percent** increase in financial and insurance activities, and a **16.2 percent** increase in agriculture, forestry, fishing, and hunting.



АНУ-ын Ерөнхийлөгч Жорж Буш Монгол Улсад айлчлав, 2005 он
US President George Bush visited Mongolia, 2005

АНУ-ын Дэд Ерөнхийлөгч Хэнри Уоллас манай улсад **1944 онд** айлчилсан. Үүнээс хойш **61** жилийн дараа буюу **2005 онд** АНУ-ын Ерөнхийлөгчийн анхны Төрийн албан ёсны айлчлалыг АНУ-ын Ерөнхийлөгч Жорж Буш, тэргүүн хатагтай Лора Буш, төрийн нарийн бичгийн дарга Кондолиза Райс нарын хамт хийжээ. Дашрамд дурдахад **1989 онд** АНУ-ын нийслэл Вашингтон хотноо Монгол Улсын Элчин сайдын яам албан ёсоор нээгдэж байжээ. Мөн **1991 оны 1 дүгээр сард** БНМАУ-ын Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат АНУ-д айлчлал хийж байв.

*Vice President of the United States Henry Wallace visited Mongolia in **1944**. **61** years after the visit, President George Bush, First Lady Laura Bush, and Secretary of State Condoleezza Rice paid a state visit to Mongolia in **2005**, the first presidential visit from the USA. The Mongolian Embassy was officially opened in Washington, DC, in **1989**. President of the Mongolian People's Republic, Ochirbat Punsalmaa visited the United States in **January 1991**.*

2005

Монгол Улсын Ерөнхийлөгчийн **4 дэх** удаагийн сонгууль болж, **931 мянган** сонгогч санал хураалтад оролцсоноос нэр дэвшигч Намбарын Энхбаяр нийт сонгогчдын **57 хувийн** саналаар Монгол Улсын **3 дахь** Ерөнхийлөгчөөр сонгогдов.

*Enkhbayar Nambar was elected as **the 3rd** President of Mongolia, winning **57 percent** of **931 thousand** voters, who participated in the **4th** presidential election of Mongolia.*



Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслол, 2005 он

Mongolian Presidential Inauguration Ceremony, 2005



УИХ-ын даргаар сонгогдсон Цэндийн Нямдоржид тамга гардуулж байгаа нь, 2005 он
Presenting the seal to Nyamdorj Tsend, Chairman of the State Great Khural, 2005

| 2005.09.03-ны өдөр УИХ-ын даргаар Цэндийн Нямдорж сонгогдов.

| *Nyamdorj Tsend was elected as Chairman of Parliament on 3 September, 2005.*

2006

Монгол Улсын Ерөнхий сайдаар **2006** оны **1** дүгээр сард Миеэгомбын Энхболд томилогдож, **2006-2007** онд ажиллав.

*Enkhbold Miyegombo was appointed as Prime Minister of Mongolia on **January of 2006** and worked between **2006 to 2007.***



Монгол Улсын Ерөнхий сайд Миеэгомбын Энхболд, 2006 он
Enkhbold Miyegombo, Prime minister of Mongolia, 2006



Тавантолгойн чулуун нүүрсний орд, 2006 он
Tavantolgoi coal mine, 2006

Уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх хувь 2005 онд **21.1 хувь** байсан бол 2006 онд өмнөх оноос **7.4 нэгж** хувиар өсөж, **28.5 хувьд** хүрчээ. Энэ нь 1990 оноос хойших хамгийн өндөр үзүүлэлт юм.

*The share of the mining sector in GDP increased from **21.1 percent** in 2005 to **28.5 percent** in 2006, an increase of **7.4 percentage** points from the previous year. This is the highest share of mining sector in GDP since 1990.*



Чингис хааны хүрэл хөшөө, 2006 он
A bronze statue of Chinggis Khaan, 2006

Их эзэн Чингис хааны хөшөө, цогцолборыг Сүхбаатарын талбайд бүтээн байгуулав.

The statue and complex of Chinggis Khan were built in Sukhbaatar Square.



Төв цэнгэлдэх хүрээлэн, 2006 он
Central stadium, 2006

Их Монгол Улс байгуулагдсаны **800** жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлэв.

The **800th** anniversary of the founding of the Great Mongol Empire was solemnly celebrated.



Авлигатай тэмцэх газрын анхны дарга Баасайн Дангаасүрэн, дэд дарга Доржийн Сундуйсүрэн нар, 2006 он
Dangaasuren Baasai and Sunduisuren Dorj, the first Director General and Deputy Director General of the Independent Authority against Corruption, 2006

2006.07.06-ны өдөр Авлигын эсрэг хуулийг УИХ батлан гаргав. Монгол Улс 2020 онд Авлигын индексээрээ **35 оноо** авч, дэлхийн **180** улсаас **111 дүгээр** байрт жагсаж байна. Энэ нь 2019 оноос **4 байраар** ухарсан үзүүлэлт юм.

*On 6 July, 2006, the Parliament adopted the Law on Anti-Corruption. In 2020, Mongolia scored **35 points** on the Corruption Perceptions Index, ranking **111th** out of **180 countries** in the world. This is a decrease of **4 places** from 2019.*



Бага ангийн сурагчид
Primary school pupils

Хүн амын төрөлтийн түвшин 20 дугаар зууны сүүлийн хагаст эрчимтэй өсөж, **1988 онд** хамгийн өндөр буюу **75.8 мянгад** хүрсэн. Нийгэм, эдийн засгийн шилжилтийн үед төрөлтийн түвшин буурч байгаад 2006 оноос эргэн нэмэгджээ. Мөн төрөлтийн түвшин 1970-1990 онд өндөр байснаас нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тоо нэмэгдсэн байна. **2014** онд хамгийн олон буюу **82.1 мянган** хүүхэд төрж байжээ.


*The birth rate increased in the second half of the 20th century, reaching a record high of **75.8** thousand in **1988**. Although the birth rate gradually dropped during the economic and social transition, it started increasing again from 2006. Also, the number of women of reproductive age increased due to high birth rates in 1970-1990. In **2014**, the largest number, or **82.1 thousand** children were born.*



2007

УИХ-ын даргаар Данзангийн Лүндээжанцанг сонгов. Тэрээр Шинэ үндсэн хууль батлагдсанаас хойш томилогдсон УИХ-ын **7 дахь** дарга юм.

Lundeejantsan Danzan was elected as Chairman of the Parliament. He was the 7th Chairman of Parliament to be appointed since the new constitution was adopted.



УИХ-ын дарга Данзангийн Лүндээжанцан, 2007 он
Lundeejantsan Danzan, Chairman of the State Great Khural, 2007

2008

Улсын Их Хурлын **5 дахь** удаагийн сонгууль болж, сонгогчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн **1.5 сая** сонгогчийн **76.5 хувь** нь саналаа өгсөн. Сонгуулийн дүнгээр МАХН **47**, Ардчилсан нам **26**, Иргэний зориг Ногоон нам **1**, Иргэний эвсэл **1**, Бие даан нэр дэвшигч **1** суудал тус тус авч, УИХ-ын даргаар Дамдингийн Дэмбэрэлийг сонгов. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдаар Санжаагийн Баяр томилогдов.

*In the **fifth** parliamentary election, **76.5 percent** of the **1.5 million** citizens voted. As a result of the election, the MPRP gained **47** seats, the Democratic Party **26** seats, the Civic Will-Green Party **1** seat, the Civil Coalition **1** seat, and an independent candidate **1** seat. Demberel Damdin was elected as Chairman of the Parliament. Bayar Sanjaa became the Prime Minister.*



Монгол Улсын Ерөнхий сайд Санжаагийн Баяр, 2008 он
Bayar Sanjaa, Prime minister of Mongolia, 2008



УИХ-ын дарга Дамдингийн Дэмбэрэл, 2008 он
Demberel Damdin, Chairman of the State Great Khural, 2008





УИХ-ын гишүүд, 2008 он
Members of the State Great Khural, 2008



Эсэргүүцэгчид МАХН-ын Төв байранд гал тавьж байгаа нь, 2008 он
Protesters setting fire in MPRP Headquarters, 2008

УИХ-ын сонгуулийн үр дүнг эсэргүүцэн цугласан иргэд **2008.07.01**-ний өдөр хуучнаар МАХН-ын Төв байр руу дайрч, цагдаагийн албан хаагчидтай мөргөлдсөнөөр **5** хүний амь үрэгдэв. Улмаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар **3 хоногийн** хугацаатай “**Онц байдал**” зарлах шийдвэрийг гаргажээ.

On **1 July, 2008, five** persons were killed when protesters set fire to the former MPRP headquarters and clashed with police. A **three day** state of emergency was declared by a Decree of the President of Mongolia.



Тайширын усан цахилгаан станц, 2008 он
Taishir water plant, 2008

Говь-Алтай аймгийн Тайшир сумын нутагт **11 мегаваттын** хүчин чадал бүхий усан цахилгаан станц **2008.08.08**-нд ашиглалтад оржээ. Цахилгаан станц ашиглалтад орсноор Завхан, Говь-Алтай аймгийн төв болон зэргэлдээх олон сумыг 24 цагийн найдвартай эрчим хүчээр хангах боломжтой болсон юм. Тус цахилгаан станц жилд **37 сая квт цаг** эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай. Манай улсын цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл 2008 оноос өмнө жилийн **0.8-5.3 хувийн** өсөлттэй байсан бол 2008 онд Тайширын усан цахилгаан станц ашиглалтад орсноор **8.1 хувийн** өсөлттэй болжээ. 1990 онд дотоодын хэрэгцээний **93.6 хувийг** үйлдвэрлэж байсан бол 2008 онд **95.3 хувь**, харин 2020 онд **80.8 хувийг** үйлдвэрлэж, үлдсэн хувийг импортоор авч байна.

*On **8 August 2008**, a hydropower plant with a capacity of **11 megawatts** was put into operation in Taishir soum, Gobi-Altai aimag. With the launch of the power plant, it was able to provide Zavkhan and Gobi-Altai aimag centers, and many neighboring soums with reliable power 24 hours a day. The power plant can generate **37 million kWh** of electricity per year. The electricity production of the country grew by **0.8-5.3 percent** a year before 2008, but in 2008 it increased by **8.1 percent** due to the launch of the Taishir hydropower plant. The country produced **93.6 percent** of domestic demand in 1990, while it produced **95.3 percent** in 2008 and **80.8 percent** in 2020, and the rest was imported.*

2009

Монгол Улсын Ерөнхийлөгчийн **5 дахь** удаагийн сонгууль болж, **1.9 сая** сонгогч санал хураалтад оролцсоноос Цахиагийн Элбэгдорж нийт сонгогчдын **51.2 хувийн** саналаар Монгол Улсын **4 дэх** Ерөнхийлөгчөөр сонгогдов.

Elbegdorj Tsakhia was elected as the 4th President of Mongolia with 51.2 percent of the votes out of 1.9 million voters, who participated in the 5th presidential election of Mongolia.





Монгол Улсын Ерөнхий сайдаар Сүхбаатарын Батболд **2009** оны **10** дугаар сард томилогдож, **2009-2012** онд ажиллав.

*Batbold Sukhbaatar was appointed as Prime Minister of Mongolia **on October of 2009**, served between **2009 to 2012**.*

Монгол Улсын Ерөнхий сайд Сүхбаатарын Батболд, 2009 он
Batbold Sukhbaatar, Prime Minister of Mongolia, 2009

ОЮУТОЛГОЙН ОРД АШИГЛАХ ТЭРЭЭНД ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ ЁСЛОЛ

2009 оны 10 дугаар сарын 6-ны өдөр, Улаанбаатар

OYUTOLGOI INVESTMENT AGREEMENT SIGNING CEREMONY

6 October 2009, Ulaanbaatar



Оюутолгойн орд газрыг ашиглах анхны гэрээг байгуулав, 2009 он
Investment agreement for the Oyutolgoi mine was signed, 2009

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлах Оюутолгойн орд газрыг ашиглах анхны гэрээг **2009.10.16**-нд “Рио Тинто групп”-тэй байгуулав. Оюутолгой болон Тавантолгойн орд газрыг ашиглаж эхэлснээр Өмнөговь аймгийн эдийн засагт үлэмж хэмжээгээр нөлөөлж эхэлсэн юм. Монгол Улсын ДНБ-д Өмнөговь аймгийн эзлэх хувь 2000 онд **1.2 хувь** байсан бол 2008 онд **1.7 хувь**, 2009 онд **2.1 хувь** болж, аймгийн ДНБ-ий салбарын бүтцэд өөрчлөлт гарч, аж үйлдвэр, барилгын салбар **56.5 хувийг** эзлэх болжээ. Харин 2020 онд аймгийн ДНБ **1.1 их наяд** төгрөг болж, улсын дүнд **2.8 хувийг** эзэлж байна.

*On **16 October 2009**, the first contract for the development of the Oyutolgoi deposit in Khanbogd soum, Umnugovi aimag, was signed with the Rio Tinto Group. The development of the Oyutolgoi and the Tavantolgoi deposits had a significant impact on the economy of Umnugovi Aimag. The share of Umnugovi Aimag in Mongolia's GDP increased from **1.2 percent** in 2000 to **1.7 percent** in 2008 and **2.1 percent** in 2009. With changes in the structure of the GDP of the aimag, industry and construction accounted for **56.5 percent** of its GDP. In 2020, the aimag's GDP amounted to **MNT 1.1 trillion**, making up **2.8 percent** of the country's GDP.*



Монголын Хөрөнгийн Бирж, 2009 он
Mongolian Stock Exchange, 2009

2009 онд Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй тусгай зөвшөөрөл бүхий **358** ААНБ үйл ажиллагаа явуулж байсан бол 2019 онд **199** болж буурсан байна. Үнэт цаасны арилжаагаар 1995 онд үнэт цаасны гүйлгээ **811.5 сая** төгрөг байсан бол 2009 онд **23.2 тэрбум** төгрөг болжээ. Харин 2020 онд **353.3 сая** ширхэг хувьцаа арилжиж, гүйлгээ **53.9 тэрбум** төгрөг хүрсэн бөгөөд 2009 онтой харьцуулахад хувьцаа **3.9 дахин**, гүйлгээ **2.3 дахин** өссөн байна.

*In 2009, there were **358 licensed** enterprises listed on the Mongolian Stock Exchange, but in 2019 the number decreased to **199**. The securities transaction was **MNT 811.5 million** in 1995 while it was **MNT 23.2 billion** in 2009. In 2020, **353.3 million** shares were traded and the turnover reached **MNT 53.9 billion**, **3.9 times** higher than those in 2009 and **2.3 times** higher than those in 2009.*

2010

Атрын III аяныг (2008-2010) бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж дотоодын хэрэгцээгээ хангах, шинэ техник, технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх зорилгоор эхлүүлэв. Аяны хүрээнд 2010 онд **345.5 мянган** тонн улаан буудай, **168 мянган** тонн төмс, **82.3 мянган** тонн хүнсний ногоо хураан авчээ. Хүн амын хэрэгцээнд 2020 онд улсын хэмжээнд **1 сая** тонн сүү, **647.8 мянган** тонн мах, махан бүтээгдэхүүн, **262.6 мянган** тонн гурил, гурилан бүтээгдэхүүн, **241.8 мянган** тонн төмс, **198.2 мянган** тонн хүнсний ногоо нийлүүлсэн байна. Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн мах, махан бүтээгдэхүүнээр **97 хувь**, төмсөөр **100 хувь**, гурилаар **98.3 хувь**, хүнсний ногоогоор **60.4 хувийг** хангаж байна.

*The **Atar III Campaign** (2008-2010) was launched to increase production and meet domestic demand and introduce new technical and technological innovations. Under this campaign, **345.5 thousand** tons of wheat, **168.0 thousand** tons of potatoes and **82.3 thousand** tons of vegetables were harvested in 2010.*

*In 2020, **1 million** tons of milk, **647.8 thousand** tons of meat and meat products, **262.6 thousand** tons of flour and bakery products, **241.8 thousand** tons of potatoes and **198.2 thousand** tons of vegetables were supplied to the consumption of the population. According to the annual food consumption of standard population, **97 percent** of domestic meat and meat products, **100 percent** of potatoes, **98.3 percent** of flour, and **60.4 percent** of vegetables are met.*



Ургац хураалт, Баянгол сум, Сэлэнгэ аймаг, 2010 он
Harvest, Bayangol soum, Selenge Aimag, 2010



Анхны хөрс хуулалт, Тавантолгойн уурхай, 2010 он
First earth-stripping, Tavan Tolgoi mine, 2010

2010.08.27-нд “Эрдэнэс Тавантолгой” төсөл хэрэгжих суурь тавигдаж, уурхайн уулын ажил албан ёсоор эхлэв. Энэ дагуу Тавантолгойн нүүрсний орд газарт ашиглалтын үйл ажиллагаа явуулах үүрэг бүхий “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийг УИХ, Засгийн газрын шийдвэрийн дагуу **2010.12.23**-нд байгуулж, үйл ажиллагаагаа эхэлсэн.

*On **27 August, 2010**, the foundation for the Erdenes Tavan Tolgoi project was laid and mining operation began officially. Accordingly, Erdenes Tavan Tolgoi Joint Stock Company, being responsible for the operation of the Tavan Tolgoi coal deposit, was established and started its operation on **23 December, 2010**, in accordance with the decision of the Parliament and the Government of Mongolia.*



Зудын улмаас хорогдсон малыг халдваргүйжүүлэн устгах цэг, Дундговь аймаг, 2010 он
A point where livestock lost due to the dzud are disinfected, Dundgovi aimag, 2010

Зудын нөхцөл байдлаас шалтгаалан 2010 онд **10.3 сая** толгой мал хорогдож, хэдөө аж ахуйн салбарын уналт эдийн засгийн өсөлтийг 2008 оноос **2.5 нэгж** хувиар бууруулав. 2010 оны жилийн эцэст манай улсын малын тоо **32.7 сая** толгойд хүрсэн бөгөөд үүний **1.9 сая** нь адуу, **2.2 сая** нь үхэр, **269.6 мянга** нь тэмээ, **14.5 сая** нь хонь, **13.9 сая** нь ямаа байв.

In 2010, a loss of **10.3 million** head of livestock due to a dzud, and collapse in the agricultural sector slowed the economic growth by **2.5 percentage** points from 2008. At the end of 2010, the number of livestock in Mongolia reached **32.7 million**, of which **1.9 million** were horses, **2.2 million** were cattle, **269.6 thousand** were camels, **14.5 million** were sheep and **13.9 million** were goats.



Сүхбаатарын талбай, 2010 он
Sukhbaatar square, 2010


Хүн ам, орон сууцны **10** дахь удаагийн тооллогыг **2010.11.11-17**-ны өдөр зохион байгуулав. Тооллогын дүнгээр манай улсын хүн ам **2 сая 754 мянга 685** болж, 2000 оноос **381.2 мянга** буюу **16.1 хувиар** өссөн байна.

The **10th** Population and Housing Census was conducted on **11-17 November, 2010**. As a result of the census, the population of our country reached **2 million 754 thousand 685**, up **381.2 thousand** or **16.1 percent** from 2000.

2011

Оюутолгойн гэрээ байгуулагдсанаар **3.6 тэрбум** ам.долларын анхны хөрөнгө оруулалт хийгдэж, уул уурхайн салбарт үсрэнгүй дэвшил гарав. Уул уурхайн салбарын нөлөөгөөр Монгол Улсын эдийн засгийн өсөлт анх удаа **17.3 хувьд** хүрчээ.

*With the signing of the Oyu Tolgoi agreement, an initial investment of **USD 3.6 billion** was made and the mining sector made great strides. For the first time, Mongolia's economic growth reached **17.3 percent** by the effect of the mining sector.*



Оюутолгойн ил уурхай, 2011 он
Oyu Tolgoi open pit mine, 2011



Жоншны уурхай, Өргөн сум, Дорноговь аймаг, 2011 он
A spar mine in Urgun soum, Dornogovi, 2011

Гадаадын шууд хөрөнгө оруулалт 2011 онд **10.1 их наяд** төгрөг болсон бөгөөд үүний **61 хувийг** уул уурхай, олборлолтын салбар эзэлж байв. Эдийн засаг **17.3 хувиар** өсөхөд тус салбар **1.7 нэгж** хувийн эерэг нөлөөтэй байв. Өмнөговь аймгийн ДНБ, оны үнээр **361.9 тэрбум** төгрөг болж, өмнөх оноос **51.6 хувиар** өссөн байна.

Foreign direct investment amounted to **MNT 10.1 trillion** in 2011, of which **61 percent** was in the mining sector. The mining sector contributed **1.7 percentage** points to **17.3 percent** economic growth. GDP of Umnugovi aimag reached **MNT 361.9 billion** at current prices, up **51.6 percent** from the previous year.



Богд хаант засгийн үеийн сайдууд
Ministers of the Bogd Khanate

Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны **100 жилийн** ойг ёслол төгөлдөр тэмдэглэв. Монгол Улсын түүхэнд **200 гаруй** жил үргэлжилсэн Манж Чин гүрний ноёрхлыг эцэс болгон Монгол төрийг сэргээн байгуулж, Монголчуудын сэргэн мандлын эхийг тавьсан юм. 1911 оны Цагаагчин гахай жилийн **шинийн 9** буюу **12 дугаар сарын 29-ний 11.00** цагт Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ололтыг баталгаажуулан Монгол Улс тусгаар тогтнолоо тунхаглан зарлаж, Богд Жавзандамба хутагтыг хаан ширээнд залж, түүнд төрийн тамга, далбаа, өргөмжлөл, хүндэтгэл өргөж, **5 яам** бүхий Засгийн газрыг байгуулах түүхэн шийдвэр гарч байжээ.

Mongolia solemnly celebrated the **100th** anniversary of the restoration of the national freedom and independence, a milestone in its history that paved the way for recreation of the Mongolian statehood and prosperity of the Mongolians by ending the Qing Dynasty regime, lasting for over **200** years in the country. On **December 29th, 1911, at 11:00 am**, Mongolia declared its independence, confirming the achievement of the national liberation revolution, exalting the Jebtsundamba Khutuktu as the King of Mongolia, and making a historic decision to form the Government with **5 ministries**.



Өргөө амаржих газар, 2011 он
Urgoo maternity hospital, 2011


Дэлхийн **7 тэрбум дахь** иргэнийг **2011.11.01**-ний өдөр тодруулсан. Энэ үед Монгол Улсад **199 хүүхэд** мэндэлснээс **19** хүүхдийг ҮСХ-ноос НҮБ-ын Хүн амын сантай хамтран “Дэлхийн **7 тэрбум дахь** иргэний үе чацуутан” хэмээн тодорхойлжээ. Эдгээр хүүхдүүд нь дэлхийн **7 тэрбум дахь** иргэнээс **90 минутын** зайтай мэндэлсэн байна.

*As the world identified its **7 billionth** person on **1 November, 2011**, there were **199 children** born in Mongolia. The NSO, in collaboration with the United Nations Population Fund, identified **19 children** out of **199** as the cohorts of the world seven billionth citizen. These children were born within **90 minutes** right after the world **7 billionth** person had been identified.*

2012

УИХ-ын **6 дахь** удаагийн сонгууль болж, нийт **1840.8 мянган** сонгогчийн **1238.5 мянга** буюу **67.3 хувь** нь саналаа өгчээ. Сонгуулийн дүнгээр АН **34**, МАН **26**, МАХН-МҮАН-ын Шударга ёс эвсэл **11**, бие даан нэр дэвшигч **3** суудал авч, хамгийн олон суудал авсан Ардчилсан нам Шударга ёс эвсэлтэй хамтран Засгийн газраа бүрдүүлэв.

The **6th** parliamentary election was held and **1238.5 thousand** or **67.3 percent** of **1840.8 thousand** voters cast their votes. As a result of the election, the DP won **34** seats, the MPP **26** seats, the MPRP-MNDP Justice Coalition **11** seats, and independent candidates **3** seats. The Democratic Party, which gained the majority of seats, formed the government in cooperation with the Justice Coalition.



Монгол Улсын Ерөнхий сайд Норовын Алтанхуяг, 2012 он
Altankhuyag Norov, Prime Minister of Mongolia, 2012



УИХ-ын дарга Зандаахүүгийн Энхболд, 2012 он
Enkhbold Zandaakhuu, Chairman of State Great Khural, 2012





УИХ-ын гишүүд, 2012 он
Members of the State Great Khural, 2012



Малчны хот, Баянговь сум, Баянхонгор аймаг, 2012 он
A herder campsite, Bayangovi soum, Bayankhongor aimag, 2012

Хөдөө аж ахуйн анхны тооллогын дүнгээр улсын хэмжээнд ХАА-н салбарт үйлдвэрлэл эрхэлдэг **243.1 мянган** өрхийн **86.2 хувь** нь мал аж ахуй, **13.8 хувь** нь газар тариалан эрхэлж байв. Мөн **2455** аж ахуйн нэгж, байгууллага байгаагаас **20.7 хувь** нь мал аж ахуй, **69.5 хувь** нь газар тариалан эрхэлж байсан. Түүнчлэн ХАА-н салбарт үйл ажиллагаа эрхлэгч өрх, ААНБ-ыг олон улсын стандарт ангиллын дагуу үйл ажиллагааны чиглэл, байршлаар нь ангилж бүртгэлээ. Газар тариалангийн тооллогод сансрын зураг ашиглан, тариалангийн талбайг байршлаар нь хянах боломж бий болж, Газар зүйн нэгдсэн санг анх удаа бүрдүүлсэн нь тооллогын бас нэг чухал үр дүн, онцлог байлаа.

According to the first Agricultural Census, of **243.1 thousand** households engaged in the agricultural industry, **86.2 percent** were in the livestock sector and **13.8 percent** in the crop sector. Also, out of **2455** establishments and enterprises, **20.7 percent** were engaged in the livestock sector and **69.5 percent** in the crop sector. In addition, households and enterprises operating in the agricultural industry were registered by areas of activity and location in accordance with international standards. The Census was of vital importance that the use of satellite imagery for the crop census taking led to the enhanced capacity to monitor crop areas by location and the establishment of the first ever unified geographical database.



Лондонгийн зуны Олимпод оролцсон Монголын баг, тамирчид, 2012 он
Mongolian national team and athletes participating in the London Summer Olympics, 2012

Монгол Улсын баг тамирчид 2012 оны Лондонгийн зуны Олимпод жүдо, бокс, чөлөөт бөх, буудлага, байт харваа, хөнгөн атлетик, усанд сэлэлтийн төрлөөр **29 эрх** авч, анх удаа хамгийн олон хүний бүрэлдэхүүнтэй оролцсон юм. Монголчууд Лондонгийн Олимпоос **2 мөнгө, 3 хүрэл** медаль хүртсэн нь Монгол Улс Олимпын наадмаас хамгийн олон медаль авсан тохиолдол байлаа.

*Mongolian athletes received **29 quotas** in judo, boxing, freestyle wrestling, shooting, archery, athletics, and swimming from the 2012 London Summer Olympics, and the largest team from the country competed in the Olympics for the first time. Mongolia won **two silver** and **three bronze** medals at the London Olympics, breaking its Olympic medal haul.*

2013

Монгол Улсын Засгийн газар, Монголбанк хамтран “Барилгын салбарыг дэмжих улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөр буюу **8 хувийн** орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэх шийдвэр гаргажээ. 2013 онд Банкнуудын ипотекийн зээлийн үлдэгдэл **2 их наяд** төгрөг, нийт зээлдэгчийн тоо **48.3 мянгад** хүрчээ.

*The Government of Mongolia and the Bank of Mongolia jointly decided to implement an **8 percent** housing and mortgage program entitled “Supporting the Construction Sector and Stabilizing Housing Prices”. In 2013, the outstanding mortgage loans of the banks reached **MNT 2 trillion** and the total number of borrowers reached **48.3 thousand**.*



Улаанбаатар хот, 2013 он
Ulaanbaatar city, 2013



Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслол, 2013 он
Mongolian Presidential Inauguration Ceremony, 2013

Монгол Улсын Ерөнхийлөгчийн **6 дахь** удаагийн сонгууль болж, **1864.3 мянган** сонгогчийн **1239.8 мянган** сонгогч санал хураалтад оролцсон бөгөөд нэр дэвшигч Цахиагийн Элбэгдорж **50.9 хувийн** саналаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөр улиран сонгогдов.

The **6th** presidential election of Mongolia was held and **1239.8 thousand** out of **1864.3 thousand** voters participated in the voting and candidate Elbegdorj Tsakhia was re-elected as President of Mongolia with a **50.9 percent** majority.

2014

Монгол Улсад 1990 онд **73.2 мянган** хүүхэд төрж байсан бол 2014 онд **82.8** мянган хүүхэд төрж, түүхэндээ хамгийн өндөр түвшинд хүрчээ. Харин 2020 онд улсын хэмжээнд **77.7 мянган** хүүхэд төрсөн байна.

*At the national level, there were **73.2 thousand** children born in 1990, while there were **82.8 thousand** children born in 2014, the highest level on record. In 2020, **77.7 thousand** children were born nationwide.*



Монгол Улсын шинэ иргэн, 2014 он
Mongolian new born citizen, 2014



Монгол Улсын Ерөнхий сайд Чимэдийн Сайханбилэг, 2014 он
Saikhanbileg Chimed, Prime Minister of Mongolia, 2014

Монгол Улсын Ерөнхий сайдаар **2014** оны **11 дүгээр** сард Чимэдийн Сайханбилэг томилогдож, **2016** оны УИХ-ын сонгууль хүртэлх хугацаанд ажиллав.

On November of 2014, Saikhanbileg Chimed became as the Prime Minister of Mongolia worked until the 2016 parliamentary election.

2015

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын иргэн Энхтүвшингийн Хатанболд, Ганбатын Аззаяа нарын гэр бүлд **2015.01.24**-нд Монголжин охин мэндэлж, Монгол Улс **3 сая** хүн амтай боллоо.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын мэдээлэлд үндэслэсэн тооцоогоор манай улсын хүн ам 2033 онд **4 сая**, 2048 онд **5 саяд** хүрэхээр байна.

*On **24 January, 2015**, the baby girl Mongoljin was born to the family of Mr. Khatanbold Enkhtuvshin and Ms. Azzaya Ganbat, natives of Dalanzadgad soum, Umnugovi aimag, and the population of Mongolia reached **3 million**.*

*According to the Population Projection, made based on the results from the 2020 Population and Housing Census, the population of the country is expected to reach **4 million** in 2033 and **5 million** in 2048.*



Монгол Улсын 3 сая дахь иргэн Монголжингийн гэр бүлд Үндэсний Статистикийн Хорооны дарга Сономцэрэнгийн Мэндсайхан зочлов. *Mendsaikhan Sonomtseren, Chairman of the National Statistics Office, visits a new born baby - Mongoljin, 3 millionth citizen of Mongolia, and her family.*



Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалт, 2015 он
The Oyutolgoi Underground Development, 2015

Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтийн гэрээнд **2015.12.15**-нд гарын үсэг зурав. Ингэснээр дэлхийн **20 гаруй** банк санхүүгийн байгууллагаас **4.3 тэрбум** ам.долларын зээлийг Оюутолгой ХХК авах нөхцөл бүрдэв.

*The Financing Agreement on Oyutolgoi Underground Development Project was signed on **15 December, 2015**. As a result, the project was in a position to receive **USD 4.3 billion** from more than **20** banks and financial institutions around the world.*

2016

2016 оны УИХ-ын сонгуулиар МАН үнэмлэхүй ялалт байгуулж, УИХ-ын даргаар Миеэгомбын Энхболдыг сонгов. Монгол Улсын Ерөнхий сайдаар Жаргалтулгын Эрдэнэбат томилогдов.

At the 2016 parliamentary election, the MPP won a landslide victory, appointing Enkhbold Miyegombo was elected as Chairman of the State Great Khural. Erdenebat Jargaltulga was appointed as the Prime Minister.



Монгол Улсын Ерөнхий сайд Жаргалтулгын Эрдэнэбат, 2016 он
Erdenebat Jargaltulga, Prime Minister of Mongolia, 2016



УИХ-ын дарга Миеэгомбын Энхболд, 2016 он
Enkhbold Miyegombo, Chairman of the Parliament, 2016



УИХ-ын гишүүд, 2016 он
Members of the State Great Khural, 2016

УИХ-ын 7 дахь удаагийн сонгуулиар **1.4 сая** сонгогч саналаа өгч, сонгуулийн дүнгээр МАН **65** суудал, АН **9** суудал, МАХН **1** суудал, Бие даан нэр дэвшигч **1** суудал тус тус авчээ.

The **7th** parliamentary election was held, **1.4 million** voters cast their votes, and the MPP won **65** seats, the DP **9** seats, the MPRP **1** seat, and an independent candidate **1** seat.

11th ASEM SUMMIT

ULAANBAATAR, MONGOLIA



Asia-Europe Meeting

20 YEARS OF ASEM | ULAANBAATAR



АСЕМ-ийн 11 дэх удаагийн уулзалт, Улаанбаатар хот, 2016 он
11th ASEM SUMMIT, Ulaanbaatar, Mongolia, 2016

Ази, Европын **50 гаруй** улсын төрийн өндөр, дээд хэмжээний зочид хүлээн авсан **11 дэх** удаагийн **АСЕМ**-ийн уулзалт Монгол Улсад амжилттай зохион байгуулагдлаа. Тус хуралд АСЕМ-ийн гишүүн **51 орон**, Олон Улсын байгууллагуудын **4000** гаруй төлөөлөгч оролцжээ.



The **11th** ASEM Summit, which brought together high-level guests from more than **50 countries** in Asia and Europe, was successfully held in Mongolia. More than **4000** delegates from **51** ASEM member countries and international organizations attended the summit.

2017

Монгол Улсын Ерөнхийлөгчийн **7 дахь** удаагийн сонгууль 2 шаттай явагдаж, **1990.8 мянган** сонгогчийн **1207.8 мянган** сонгогч санал хураалтад оролцож, **50.6 хувийн** саналаар Халтмаагийн Баттулга Монгол Улсын **5 дахь** Ерөнхийлөгчөөр сонгогдов.

*The 7th presidential election of Mongolia was held in two stages and **1207.8 thousand** out of **1990.8 thousand** voters participated in the voting. Battulga Khaltmaa was elected as the **5th President of Mongolia with a 50.6 percent** majority.*



Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслол, 2017 он
Mongolian Presidential Inauguration Ceremony, 2017



Монгол Улсын Ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүх, 2017 он
Khurelsukh Ukhnaa, Prime Minister of Mongolia, 2017

Монгол Улсын Ерөнхий сайдаар **2017** оны **9** дүгээр сард Ухнаагийн Хүрэлсүх томилогдож, **2021** оны **1** дүгээр сар хүртэл ажиллав.

On September of 2017, Khurelsukh Ukhnaa was appointed as the Prime Minister of Mongolia and worked until January 2021.





Зөвлөлдөх санал асуулга, Төрийн ордон, 2017 он
Deliberative Poll, Government Palace, 2017

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулгын эхний шатны асуулгыг улс орон даяар санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон **1570 иргэнээс** авсан байна. Хоёр дахь шатны зөвлөлдөх санал асуулгад оролцогч **785 иргэнийг** дээрх санал асуулгад оролцсон иргэдээс мөн санамсаргүй түүврийн аргаар сонгож, төрийн ордонд хэлэлцүүлэг зохион байгуулав.

*The initial stage of the first National Deliberative Poll on Constitutional Amendment was conducted using a random sampling design in which **1570 citizens** were selected citizens. In the second stage of the poll, **785 citizens** were randomly selected from the respondents in the initial stage and a panel discussion was held at the Government House.*

2018

Дотоодын нефтийн хэрэгцээг бүрэн хангах боломжтой, жилд **1.5 сая** тонн түүхий тос боловсруулах хүчин чадалтай газрын тос боловсруулах үйлдвэр Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдаж эхлэв. Нийт **1 тэрбум** ам.долларын өртөгтэй энэхүү төслийг Монгол Улсын Засгийн газар, БНЭУ-ын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж байгаа юм.

*Construction of an oil refinery with a capacity of **1.5 million** tons of crude oil per year, which can fully meet national demand of has been started in Altanshiree soum of Dornogovi aimag within the framework of intergovernmental cooperation between the Government of India and Mongolia. The total estimated cost of the project is **USD 1 billion**.*



Газрын тос боловсруулах үйлдвэрийн шав тавих ёслол, Дорноговь аймаг, 2018 он
Groundbreaking ceremony of a Oil Refinery Plant, Dornogovi aimag, 2018



Төмөр зам, Сэлэнгэ аймаг, 2018 он
Railway, Selenge aimag, 2018

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор “Тавантолгой-Зүүнбаян” чиглэлийн **416.1 км**, “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн **267 км** төмөр замын төслийн ажил хэрэгжиж эхлэв. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам ашиглалтад орсноор жилд **15 сая** тонн ачаа тээвэрлэхээс гадна уул уурхайн бүтээгдэхүүнийг **2 дахин** хямд зардлаар тээвэрлэж, **1000** орчим ажлын байр шинээр бий болно. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам ашиглалтад орсноор нүүрс тээвэрлэлтийн зардал **2.5 дахин** буурах бөгөөд жилд **30-52 сая** тонн нүүрс экспортлох, мөн **2200** орчим байнгын болон түр ажлын байр бий болж, хүн амын амьжиргаа дээшлэх боломж бүрдэх юм.

According to a Government Resolution, a construction of **416.1 km** railway connecting Tavan Tolgoi with Zuunbayan and of a **267 km** railway connecting Tavan Tolgoi with Gashuunsukhait commenced. The development of the Tavan Tolgoi-Zuunbayan railway will not only transport **15 million** tons of freight per year but also transport mining products at a cost **twice** and create around **1000** new jobs.

The development of the Tavan Tolgoi-Gashuunsukhait railway will reduce coal transportation costs by **2.5 times**, export **30-52 million** tons of coal a year, create about **2200** permanent and temporary jobs, and improve the living standards of the population.

2019

2019 онд УИХ-ын даргаар Гомбожавын Занданшатар томилогдов.

In 2019, Zandanshatar Gombojav was appointed as Chairman of the Parliament.



УИХ-ын дарга Гомбожавын Занданшатар, 2019 он
Zandanshatar Gombojav, Chairman of the Great State Khural, 2019



Шинэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлав, 2019 он
Adapted the amendments to the constitution, 2019

2019.11.14-нд Үндсэн хуулийн **19 зүйл, 36 хэсэгт** өөрчлөлт оруулж, тус өөрчлөлтийг Үндсэн хуулийн **95 жилийн** ойн өдрөөр Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга ёсчлон баталгаажуулав.

*On 14th of November, 2019, the 95th anniversary of the Constitution, Battulga Khaltmaa, President of Mongolia, ratified the Constitutional Amendment that covered **19 articles and 36 clauses** in the Constitution.*

2020

Улсын Их Хурлын **8 дахь** удаагийн сонгууль болж, бүртгэгдсэн **2004.0 мянган** сонгогчийн **1475.8 мянган** сонгогч буюу **73.6 хувь** нь санал хураалтад оролцож, сонгуулийн үр дүнгээр МАН **62**, АН **11**, МАХН **1**, Зөв хүн электорат эвсэл **1**, бие даан нэр дэвшигч **1 суудал** тус тус авчээ.

УИХ-ын даргаар Гомбожавын Занданшатар улиран сонгогдов.

*The **8th** parliamentary election was held and **1475.8 thousand** voters or **73.6 percent** of the registered **2004.0 thousand** voters took part in the voting, and the MPP won **62** seats, the DP **11** seats, the MPRP **1** seat, the Right Person Electorate Coalition **1** seat, and an independent candidate **1** seat.*

Zandanshatar Gombojav was re-elected as Chairman of the Parliament.

УИХ-ын дарга Гомбожавын Занданшатар, 2020 он
Zandanshatar Gombojav, Chairman of the Great State Khural, 2020





УИХ-ын гишүүд, 2020 он
Members of the State Great Khural, 2020



Цар тахлын хатуу хөл хорионы дэглэмд шилжив, Улаанбаатар хот, 2020 он
Lockdown due to COVID-19, Ulaanbaatar, 2020

2020 оны 1 дүгээр сард БНХАУ-ын Ухань хотод шинэ төрлийн Коронавируст халдварын анхны тохиолдол бүртгэгдэж, Монгол Улс **2020.01.27**-ны өдөр “Бэлэн байдлын зэрэг”-т шилжлээ. Цар тахлын тархалтын эсрэг хөл хорио нь Монгол Улсын нийгэм, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж, эдийн засаг **4.6 хувиар** буурав.

*In January 2020, the first case of a new type of coronavirus was registered in Wuhan, China, and Mongolia entered the Readiness Level on **January 27, 2020**. The quarantine against the spread of the pandemic negatively affected the economy of Mongolia, resulting in a **4.6 percent** decline in the economy.*



ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГО-2020



ИРГЭН ТА

<http://e-registration.nso.mn/web>

цахим хуудсанд хандаж өөрийн
мэдээллээ баталгаажуулна уу



Хүн ам орон сууцны тооллогын зурагт хуудас, 2020 он
Poster of Population and Housing Census, 2020

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр манай улсын
хүн ам **3 296 866** болж, өмнөх тооллогоос **19.7 хувиар** өсжээ.

According to the results from the Population and Housing Census 2020, the
population of our country reached **3 296 866** persons, up **19.7 percent**
from the previous census.

2021

Монгол Улс цар тахлын эсрэг вакцинжуулалтаа **2021.02.23**-наас эхэлж, насанд хүрсэн иргэдийг вакцины **3 тунгаар** дархлаажуулав. 2021 оны эцсийн байдлаар нийт хүн амын **69.7 хувь** нь вакцины **I тун**, **66.5 хувь** нь **II тун**, **28 хувь** нь **III тунд** хамрагдсан байна.

*Mongolia started a vaccination campaign against the pandemic on **23 February, 2021**, and managed to have its adult population receive **3 doses** of a vaccine. As of the end of 2021, **69.7 percent** of the total population received **one dose** of a vaccine, **66.5 percent** had **two doses**, and **28 percent** had **three doses**.*



Цар тахлын эсрэг вакцинжуулалт, 2021 он
Vaccination against COVID-19, 2021



Монгол Улсын зургаа дахь Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх, 2021 он
Khurelsukh Ukhnaa, 6th President of the Mongolia

Монгол Улсын Ерөнхийлөгчийн **8 дахь** удаагийн сонгууль болж, бүртгэгдсэн **2 сая 42 мянган** сонгогчоос **59.4 хувь** нь санал хураалтад оролцжээ. Сонгуулийн дүнгээр нэр дэвшигч Ухнаагийн Хүрэлсүх сонгогчдын **67.7 хувийн** санал авч, Монгол Улсын **6 дахь** Ерөнхийлөгчөөр сонгогдов.

The **8th** presidential election of Mongolia was held and **59.4 percent** of the **2 million 42 thousand** registered voters participated in the voting. As a result of the election, candidate Khurelsukh Ukhnaa won **67.7 percent** of the total votes and was elected as the **6th** President of Mongolia.



Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, 2021 он
Oyun-Erdene Luvsannamsrai, Prime Minister of Mongolia, 2021

Монгол Улсын Ерөнхий сайдаар **2021** оны **1 дүгээр сард** Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийг томилов.

Oyun-Erdene Luvsannamsrai was appointed as the Prime Minister of Mongolia on January of 2021.



Мянганы зам, Хэнтий аймаг, 2021 он
Millennium Road. Khentii aimag, 2021

Манай улсын хатуу хучилттай замын сүлжээний урт 1992 онд **1250 км** байсан бол 2021 онд **10243.8 км** болсноор Улаанбаатар хот, 21 аймагтай хатуу хучилттай авто замаар бүрэн холбогдсон.

*The length of the paved road network of our country was **1250 km** in 1992 and increased to **10243.8 km** in 2021, fully connecting Ulaanbaatar city with 21 aimags.*

МОНГОЛ УЛСЫН ШИНЭ ҮНДСЭН ХУУЛЬ

New constitution of Mongolia



МОНГОЛ УЛСЫН
СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ

Statistical information of Mongolia

1.1 МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТОО, хүйс, хот, хөдөө, хүйсийн харьцаа, хүн ам зүйн ачаалал, өсөлтийн хувь
POPULATION OF MONGOLIA, by sex, urban and rural, sex ratio, dependency ratio, population growth

Үзүүлэлт	Indicator	1989	1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004
		мянган хүн / thousand persons															
Бүгд	Total	2 099.1	2 153.4	2 177.2	2 158.4	2 171.9	2 206.9	2 243.0	2 276.0	2 307.5	2 340.1	2 373.5	2 403.1	2 432.4	2 465.6	2 495.1	2 521.7
Эрэгтэй	Male	1 046.7	1 073.6	1 085.4	1 076.0	1 082.5	1 096.8	1 114.4	1 129.8	1 145.6	1 161.6	1 178.0	1 190.2	1 204.7	1 223.2	1 237.8	1 251.0
Эмэгтэй	Female	1 052.4	1 079.8	1 091.8	1 082.4	1 089.4	1 110.1	1 128.6	1 146.2	1 161.9	1 178.5	1 195.5	1 212.9	1 227.7	1 242.4	1 257.3	1 270.7
б. Хот, хөдөөгийн хүн ам / Urban and rural population																	
Хот	Urban	1 200.7	1 226.5	1 241.0	1 219.3	1 226.9	1 205.6	1 202.3	1 181.2	1 146.6	1 160.2	1 344.5	1 361.3	1 396.4	1 437.5	1 487.7	1 527.9
Хөдөө	Rural	898.4	926.9	936.2	939.1	945.0	1 001.3	1 040.7	1 094.8	1 160.9	1 179.9	1 029.0	1 041.8	1 036.0	1 028.2	1 007.4	993.8
в. Хүн ам зүйн ачаалал / Dependency ratio																	
Бүгд	Total	84.8	83.7	82.4	80.5	77.3	73.9	71.9	69.7	67.5	65.2	64.6	59.5	56.9	56.6	56.6	56.6
Хүүхэд	Child	77.2	76.2	75.0	73.3	70.4	67.5	65.4	63.3	61.0	58.8	58.9	53.9	51.4	51.1	51.1	51.1
Хөгшид	Elderly	7.6	7.5	7.4	7.2	6.9	6.4	6.5	6.4	6.5	6.4	5.7	5.6	5.5	5.5	5.5	5.5
Хүйсийн харьцаа	Sex ratio	99.5	99.4	99.4	99.4	99.4	98.8	98.7	98.6	98.6	98.6	98.5	98.1	98.1	98.5	98.4	98.4
Голч нас (жилээр)	Median age (by year)	18.7	18.9	19.0	19.2	19.6	20.1	20.5	20.9	21.2	21.7	21.6	22.2	22.6	22.5	22.5	22.5
Хүн амын өсөлт (хувиар)	Population growth (by percentage)	2.7	2.6	1.1	-0.9	0.6	1.6	1.6	1.5	1.4	1.4	1.4	1.2	1.2	1.4	1.2	1.1

Үзүүлэлт	Indicator	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
		мянган хүн / thousand persons															
Бүгд	Total	2 551.1	2 583.3	2 620.4	2 666.0	2 716.3	2 761.0	2 811.6	2 867.7	2 930.3	2 995.9	3 057.8	3 119.9	3 177.9	3 238.5	3 296.9	3 357.5
Эрэгтэй	Male	1 265.6	1 259.7	1 277.2	1 301.3	1 328.2	1 342.1	1 364.7	1 393.4	1 425.8	1 466.4	1 503.6	1 534.0	1 562.4	1 591.9	1 619.6	1 649.0
Эмэгтэй	Female	1 285.5	1 323.6	1 343.2	1 364.7	1 388.1	1 418.9	1 446.9	1 474.3	1 504.5	1 529.5	1 554.2	1 585.9	1 615.5	1 646.6	1 677.3	1 708.5
б. Хот, хөдөөгийн хүн ам / Urban and rural population																	
Хот	Urban	1 579.4	1 621.7	1 655.4	1 713.1	1 772.9	1 910.8	1 896.2	1 926.6	1 995.7	1 990.3	2 096.2	2 131.8	2 146.7	2 198.0	2 259.0	2 316.5
Хөдөө	Rural	971.7	961.6	965.0	952.9	943.4	850.2	915.4	941.1	934.6	1 005.6	961.6	988.1	1 031.2	1 040.5	1 037.9	1 041.0
в. Хүн ам зүйн ачаалал / Dependency ratio																	
Бүгд	Total	56.6	48.6	48.6	47.6	46.4	45.4	43.8	44.6	45.3	47.1	50.1	51.1	52.3	53.6	55.3	56.6
Хүүхэд	Child	51.1	42.4	42.5	41.5	40.5	39.7	38.3	39.1	39.8	41.3	44.4	45.4	46.4	47.5	48.9	49.9
Хөгшид	Elderly	5.5	6.2	6.1	6.1	5.9	5.7	5.5	5.5	5.5	5.8	5.7	5.7	5.9	6.1	6.4	6.7
Хүйсийн харьцаа	Sex ratio	98.5	95.2	95.1	95.4	95.7	94.6	94.3	94.5	94.8	95.9	96.7	96.7	96.7	96.7	96.6	96.5
Голч нас (жилээр)	Median age (by year)	22.5	24.8	24.8	25.1	25.5	25.8	26.3	26.6	26.8	27.1	26.8	27.1	27.4	27.7	27.9	28.1
Хүн амын өсөлт (хувиар)	Population growth (by percentage)	1.2	1.3	1.4	1.7	1.9	1.6	1.8	2.0	2.2	2.2	2.1	2.0	1.9	1.9	1.8	1.8

1.2 МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТОО, бүс, аймаг, нийслэлээр POPULATION OF MONGOLIA, by region, aimags and the Capital

Аймаг, нийслэл	Aimags and the Capital	1989*	1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999
Бүгд	Total	2 043 954	2 153 466	2 177 217	2 158 362	2 171 898	2 206 892	2 242 998	2 276 016	2 307 484	2 340 134	2 373 493
Баруун бүс	Western region	402 713	426 119	434 948	421 004	411 351	417 549	422 977	426 743	428 627	428 585	421 608
Баян-Өлгий	Bayan-Ulgii	90 911	99 022	100 171	83 632	73 116	76 585	79 793	82 575	85 502	88 279	91 068
Говь-Алтай	Govi-Altai	62 773	64 744	65 935	66 530	66 394	66 413	66 581	66 601	66 359	65 676	63 673
Завхан	Zavkhan	88 518	92 159	94 263	95 782	95 658	95 881	95 876	95 787	95 119	93 840	89 999
Увс	Uvs	83 958	88 810	91 256	93 345	94 328	95 421	95 897	95 910	94 701	93 760	90 037
Ховд	Khovd	76 553	81 384	83 323	81 715	81 855	83 249	84 830	85 870	86 947	87 030	86 831
Хангайн бүс	Khangai region	465 480	491 068	500 951	509 728	516 534	523 565	531 163	537 470	543 261	547 212	545 654
Архангай	Arkhangai	84 517	88 992	91 127	93 070	94 067	95 116	96 108	97 148	97 866	98 416	97 091
Баянхонгор	Bayankhongor	74 574	78 086	80 289	81 737	82 094	82 822	83 779	84 572	85 203	85 581	84 779
Булган	Bulgan	51 910	55 179	56 644	57 994	58 643	59 269	60 057	60 741	61 477	62 192	61 776
